



НИЙСЛЭЛИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗАР
ULAANBAATAR CITY HEALTH DEPARTMENT

НИЙСЛЭЛИЙН ХҮН АМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЗҮҮЛЭЛТ

HEALTH INDICATORS OF THE
ULAANBAATAR CITY POPULATION

2018



Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Эрүүл мэндийн газар

Шуудангийн хаяг: 15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Бага тойруу 3, Жигжиджавын гудамж, Хангарди ордон 9 давхар

Энэхүү эмхтгэлийн талаархи саналыг дараах хаягаар ирүүлнэ үү.

Утас: 329114
 Э-шуудан: Info@ubhealth.mn, nemg.statistic2019@gmail.com
 Вебсайт: http://www.emg.ub.gov.mn

Эрхэлсэн: Л.Төмөрбаатар, НЗДХА - Эрүүл мэндийн газрын дарга

Хянасан: Л.Зэндмаа, Орлогч дарга
 Н.Долгормаа, Статистик, мэдээллийн хэлтсийн дарга
 С.Ариунтуяа

Эмхэтгэсэн: А.Оюунгэрэл, Статистик, мэдээллийн хэлтсийн мэргэжилтэн
 Г.Дэлгэрсүрэн, Статистик, мэдээллийн хэлтсийн мэргэжилтэн
 Б.Сэргэлэн, Статистик, мэдээллийн хэлтсийн мэргэжилтэн
 Н.Уранхайч, Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн

Ulaanbaatar City health department implementing agency of the mayor of Ulaanbaatar city

Ulaanbaatar city, Health Authority 9F, "Khangardi" Palace, Baga toiruu-15160, Jigjidjav Ts, street -3, Chingeltei District, Ulaanbaatar -102160002, Mongolia.

Please send your comments regarding this publication to the address below.

Telephone: 329114
 E-mail: Info@ubhealth.mn, nemg.statistic2019@gmail.com
 Website: http://www.emg.ub.gov.mn
 Supervised by: L.Tumurbaatar, Director of UBHD
 Edited by: L.Zendmaa, Deputy director of UBHD
 N.Dolgormaa, Head of Statistics and Information Division
 S.Ariuntuya

Complied by: A.Oyungerel, Officer, Statistics and Information Division
 G.Delgersuren, Officer, Statistics and Information Division
 B.Sergelen, Officer, Statistics and Information Division
 N.Urankhaich, Officer, Division of Funding and investment



ГАРЧИГ

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР	5
ӨМНӨХ ҮГ	7
ХУРААНГУЙ ҮЗҮҮЛЭЛТ	9
Бүлэг I. ХҮН АМ.....	10-19
1.1. Монгол Улсын хүн ам (Улаанбаатар хотын хүн ам).....	10
1.2. Хүн ам зүйн үндсэн үзүүлэлт, дундаж наслалт	11
1.3. Тогтвортой хөгжил.....	16
Бүлэг II. ЭХ, ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЗҮҮЛЭЛТ	20-43
2.1. Жирэмсний хяналт ба төрөхийн өмнөх үеийн эмнэлгийн тусламж үйлчилгээ	20
2.2. Төрөлт, төрөх үеийн эмнэлгийн тусламж үйлчилгээ	22
2.3. Төрсний дараах үеийн эмнэлгийн тусламж үйлчилгээ	27
2.4. Эхийн эндэгдэл	29
2.5. Жирэмслэлтээс сэргийлэх орчин үеийн арга, хэрэглээ	31
2.6. Үр хөндөлт	32
2.7. Хүүхдийн эрүүл мэнд.....	34
2.8. Нялхас болон тав хүртэлх насны хүүхэд, өсвөр насны хүүхдийн эндэгдэл	36
Бүлэг III. ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ	44-63
3.1. Амбулаторийн тусламж, үйлчилгээ	45
3.2. Хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээ	50
3.3. Эмнэлгийн тусламж үйлчилгээ шатлалаар.....	53
Бүлэг IV. НИЙСЛЭЛИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫН БҮТЭЦ, ХҮНИЙ НӨӨЦ.....	64-67
Бүлэг V.ХАЛДВАРТ ӨВЧИН	68-82
5.1. Амьсгалын замын халдвар	69
5.2. Гэдэсний халдвар	77
5.3. Бэлгийн замаар дамжих халдвар	80
Бүлэг VI. ХАЛДВАРТ БУС ӨВЧИН.....	83-111
6.1. Хүн амын нийт өвчлөл.....	83
6.2. Хүүхэд өсвөр үеийнхний өвчлөл.....	93
6.3. Хорт хавдрын өвчлөл	96
6.4. Халдварт бус өвчний эрт илрүүлэг.....	104
6.5. Сэтгэцийн эрүүл мэнд	107
6.6. Хэвтэн эмчлүүлэгсдийн өвчлөл	108
Бүлэг VII. ХҮН АМЫН НАС БАРАЛТ	112-123
7.1. Хүн амын нас баралтын тэргүүлэх шалтгаан	112
7.2. Хорт хавдрын нас баралт.....	115
7.3. Осол гэмтлийн нас баралт	122
Бүлэг VIII. НИЙСЛЭЛИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТ	124-129
Бүлэг IX. ДЭЛХИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫН НОМХОН ДАЛАЙН БАРУУН БҮСИЙН МЭДЭЭНИЙ САНД ОРДОГ ҮЗҮҮЛЭЛТ, УЛААНБААТАР ХОТ	130-135



TABLE OF CONTENTS

LIST OF ACRONYMS	6
FOREWORD	8
ABSTRACT	9
Chapter I. POPULATION	10-19
1.1. Population of Mongolia (Population of Ulaanbaatar)	10
1.2. Selected demographic indicators.	11
1.3. Sustainable Development Goals.	16
Chapter II. MATERNAL AND CHILD HEALTH	20-43
2.1. Prenatal and antenatal care and services	20
2.2. Labor and birth medical health care services.	22
2.3. Post-partum health care services.	27
2.4. Maternal mortality	29
2.5. Use of modern methods of contraception	31
2.6. Abortions.	32
2.7. Child health	34
2.8. Infant and under five mortality	36
Chapter III. MEDICAL SERVICES	44-63
3.1. Ambulance services.	45
3.2. Inpatient services.	50
3.3. Medical care services, by stage	53
Chapter IV. STRUCTURE OF THE HEALTH ORGANIZATIONS OF THE CAPITAL, HUMAN RESOURCES	64-67
Chapter V. COMMUNICABLE DISEASES	68-82
5.1. Respiratory infections	69
5.2. Intestinal infections.	77
5.3. Sexually transmitted infections	80
Chapter VI. NON-COMMUNICABLE DISEASES	83-109
6.1. Total population morbidity	83
6.2. Child and teenager morbidity	93
6.3. Incidence of cancer	96
6.4. Screening for Non-communicable diseases.	104
6.5. Mental health care and service.	107
6.6. Inpatient morbidity	108
Chapter VII. POPULATION MORTALITY	112-123
7.1. Leading causes of mortality	112
7.2. Mortality due to cancer	115
7.3. Mortality due to injury and accidents.	122
Chapter VIII. ECONOMIC INDICATORS OF THE HEALTH SECTOR OF THE CAPITAL CITY	124-129
Chapter IX. HEALTH INDICATORS, WESTERN PACIFIC DATABASE, WHO, 2018. ULAANBAATAR	130-135



ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

АХБ	Азийн хөгжлийн банк
БГД	Баянгол дүүрэг
БЗД	Баянзүрх дүүрэг
БЗДХ	Бэлгийн замаар дамжих халдвар
БНД	Багануур дүүрэг
БХД	Багахангай дүүрэг
ВХА	Вируст хепатит А
ВХВ	Вируст хепатит В
ВХС	Вируст хепатит С
ГССҮТ	Гэмтэл согог судлалын үндэсний төв
ДЭМБ	Дэлхийн эрүүл мэндийн байгууллага
ДОХ	Дархлалын олдмол хомсдол
ДОТС	Шууд хяналттай богино хугацааны эмчилгээ
ЖСА	Жирэмслэлтээс сэргийлэх арга
НБЕК	Нас баралтын ерөнхий коэффициент
НЭМ	Нийгмийн эрүүл мэнд
НЭМГ	Нийслэлийн эрүүл мэндийн газар
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НД	Налайх дүүрэг
НҮЭМ	Нөхөн үржихүйн эрүүл мэнд
ОЭТС	Олон эмэнд тэсвэртэй сүрьеэ
ӨОУА	Өвчний Олон Улсын ангилал
СБД	Сүхбаатар дүүрэг
СХД	Сонгинохайрхан дүүрэг
ТЕК	Төрөлтийн ерөнхий коэффициент
ТНК	Төрөлтийн нийлбэр коэффициент
ТТК	Төрөлтийн тусгай коэффициент
УБ	Улаанбаатар
УНТЭ	Улсын нэгдүгээр төв эмнэлэг
УХТЭ	Улсын хоёрдугаар төв эмнэлэг
УГТЭ	Улсын гуравдугаар төв эмнэлэг
ХУД	Хан-Уул дүүрэг
ХӨСҮТ	Халдварт өвчин судлалын үндэсний төв
ХСҮТ	Хавдар судлалын үндэсний төв
ХДХВ	Хүний дархлал хомсдолын вирус
ХХЭМБ	Хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага
ЧД	Чингэлтэй дүүрэг
ЭМЯ	Эрүүл мэндийн яам
ЭХЭМҮТ	Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв
ЭМТ	Эрүүл мэндийн төв
ЭМД	Эрүүл мэндийн даатгал



LIST OF ACRONYMS

ADB	Asian Development Bank
BGD	Bayangol district
BZD	Bayanzurkh district
STI	Sexually transmitted infections
BND	Baganuur district
BHD	Bagakhangai district
VHA	Viral Hepatitis A
VHB	Viral Hepatitis B
VHC	Viral Hepatitis C
NCTO	National Center of Traumatology and Orthopaedics
WHO	World Health Organization
HIV	Human immunodeficiency virus
DOTS	Directly observed treatment short-course
MMC	Modern contraceptive method
CDR	Crude death rate
PH	Public health
UBHD	Ulaanbaatar City health department
SID	Social insurance deduction
ND	Nalaikh district
RH	Reproductive Health
MDRTB	Multi-drug-resistant tuberculosis
ICD	International classification disease
SBD	Sukhbaatar district
SHD	Songinokhairkhan district
CBR	Crude birth rate
TFR	Total fertility rate
UB	Ulaanbaatar
I SCH	I State Central Hospital
II SCH	II State Central Hospital
III SCH	III State Central Hospital
KhUD	Khan Uul district
NIDC	National Infectious Diseases Centre
NCC	National Cancer Center
PR	Private organization
ChD	Chingeltei district
MOH	Ministry of Health
NCMCh	National Center for Mother and Child
HC	Health center
FA	First aid
HIP	Health Insurance premium

ӨМНӨХ ҮГ



Нийслэлийн Эрүүл мэндийн газраас эрүүл мэндийн байгууллагуудын албан ёсны статистик мэдээ, тайланд тулгуурлан, эрүүл мэндийн үндсэн үзүүлэлтийг олон улсын аргачлалын дагуу тооцож, боловсруулалт хийж эмхэтгэн жил бүр бодлого боловсруулагч, шийдвэр гаргагч, эмч, эмнэлгийн мэргэжилтэн нарт хүртээл болгож байна.

Монгол Улсын хүн ам 2018 онд 3.238.4 мянгад хүрч, өмнөх оноос 60.5 мянган хүнээр буюу 1.9 хувиар нэмэгдэж хүн амын дундаж наслалт 70.19

боллоо. Нийслэл Улаанбаатар хотын хүн ам жилээс жилд өсөн нэмэгдэж, 1.444.6 мянган хүн ам болж өнгөрсөн оноос 27.2 мянган хүнээр буюу 1.9 хувиар өслөө. 2018 оны жилийн эцсийн байдлаар Нийслэлийн хүн амд 2617 улсын болон хувийн эрүүл мэндийн байгууллага тусламж үйлчилгээ үзүүлж байна.

Мөн “Эрүүл зүрх-Эрүүл Улаанбаатар”, “Хамгаалах бүс, хамгаалах малгайн хэрэглээг хэвшүүлснээр зам, тээврийн аюулгүй байдлыг сайжруулах” төслийг шинээр, “Элэг бүтэн Монгол” хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэн ажиллалаа. Энэхүү төслүүд хэрэгжсэнээр зүрх судасны тогтолцооны болон осол гэмтлийн өвчлөл, нас баралтын шалтгааныг илрүүлэх, хянах үйл ажиллагааг оновчтой зохион байгуулах, өвчлөл, хүндрэл, эндэгдлийг бууруулахад ихээхэн ач холбогдолтой юм.

Хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын жилийн эцсийн хүний нөөц, хүчин чадал, үйл ажиллагаа, улирлын орлого зарлагын мэдээ тайланг хүлээн авах цахим програмыг нэвтрүүлж эхэлснээр 2000 гаруй хувийн эмнэлэг, сувилал, эмийн сангийн мэдээ тайлан үнэн зөв, хяналттай болох, цаг хугацаа хэмнэх, эмч, ажилтнуудын ачаалал, чирэгдэл багасах, мэдээний нэгдсэн сан үүсэх боломж бүрдлээ.

Энэхүү 2018 оны эмхэтгэлд хүн ам зүйн үндсэн үзүүлэлт, эх, хүүхдийн эрүүл мэндийн үзүүлэлт, эрүүл мэндийн салбарт ажиллаж буй эмч эмнэлгийн мэргэжилтнүүд, эмнэлгийн тусламж үйлчилгээний үзүүлэлт болон хүн амын өвчлөл, нас баралтын тэргүүлэх шалтгаан, нийслэлийн эрүүл мэндийн салбарын санхүүжилт, хөрөнгө оруулалтын үндсэн үзүүлэлтийг нэгтгэн, 9 бүлэг бүхий мэдээллийг улс, аймгийн дундажтай харьцуулан, дүн шинжилгээ хийж монгол-англи хэлнээ Та бүхэнд хүргүүлж байна.

Нийслэлийн хүн амын эрүүл мэндийн статистик үзүүлэлтийн сар, улирал, жилийн мэдээллийг манай цахим хуудас болох www.mn.emg.ub.gov.mn-д хандан хэрэглэгч Та шаардлагатай мэдээллээ авах боломжтой.

Энэхүү эмхэтгэл нь бодлого боловсруулагч, бүх түвшний эрүүл мэндийн байгууллагын удирдах ажилтан болон эмч, мэргэжилтэн, бусад мэдээлэл хэрэглэгчдэд нотолгоонд тулгуурласан оновчтой шийдвэр гаргахад дэмжлэг үзүүлнэ гэдэгт найдаж байна.

НИЙСЛЭЛИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН
ДАРГА



Л.ТӨМӨРБААТАР



FOREWORD



Ulaanbaatar City Health Department (UBCHD) presents annual report of essential health indicators, estimated using data collected from health organizations using standard international methodology for policy and decision makers as well as health professionals.

In 2018, the population of Mongolia reached 3.2384 million, an increase by 1.9% compared to the previous year. Life expectancy is estimated to be 70.19 years. The population of the Capital city has been steadily increasing over the recent

years reaching 1,444.6 thousand in 2018. By the end of 2018 total of 2617 public and private health organizations reported to provide health services in Ulaanbaatar.

In 2018, two new public health programs namely “Healthy Heart-Healthy Ulaanbaatar” and “Reducing road traffic safety by ensuring seatbelt and helmet use” were introduced and the “Whole Liver-Mongolia” is being continued. These programs aim at identifying causal determinants associated with cardiovascular disease, injuries and accidents and preventing complications and deaths due to these diseases.

A new software for collecting data from private clinics and hospitals was introduced in 2018 which enabled collection of human resource, service and financial data from over 2000 private health organizations in timely and accurate manner. The software serves as tool for establishing uniform database for all private health facilities and helps to reduce load of health workers responsible for reporting data.

The 2018 volume presents groups of main health, demographic, maternal and child, human resources and medical care indicators of the capital city, leading causes of morbidity and mortality, financial data of the UB city health sector in 9 chapters. It illustrates analysis and comparison of the indicators and data with country and aimag average.

Monthly, quarterly and annual health information of the UB city is accessible for the general public at webpage www.mn.emg.ub.gov.mn.

We hope the annual report will serve as useful tool for evidence based policy and decision making by health managers at all levels of care, health professionals and other users.

DIRECTOR OF ULAANBAATAR CITY HEALTH
DEPARTMENT  DR. TUMURBAATAR L.



ХУРААНГУЙ ҮЗҮҮЛЭЛТ / ABSTRACT

Үзүүлэлт / Indicator	Монгол Улс / Mongolia	Улаанбаатар хот / Ulaanbaatar city
Хүн ам / Population		
Нийт/ Total	3238479	1444669*
Үүнээс: эрэгтэйчүүдийн эзлэх хувь Per males	49.2	48.4
эмэгтэйчүүдийн эзлэх хувь per female	50.8	51.6
ТЕК/ CBR	24.5	28.4
ТНК/ TBR	2.9	2.7
НБЕК / CDR	5.1	5.7
Цэвэр өсөлт /Growth rate	19.0	22.7
Дундаж наслалт /Average life expectancy	70.19	71.65
Эх хүүхдийн эрүүл мэнд /Maternal and child health		
Төрсөн эх /Mothers gave birth	77058	40373
Амьд төрсөн хүүхэд /Number of live births	77528	40703
Эхийн эндэгдэл 100000 амьд төрөлтөд /Maternal mortality rate (per 100 000 live births)	27.1	27.0
Нэг хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин /Infant mortality /per 1000 live births/	13.4	13.6
Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин /Under-five mortality /per 1000 live births/	16.9	16.1
Амьгүй төрөлтийн түвшин /Stillbirth rate per 1000 births	5.6	6.4
Жирэмсний эрт хяналтын хувь /Early antenatal care services	88.1	88.5
Хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээ /In-patient health care services		
Дундаж ор хоног /Average length of stay	7.1	7.1
Орны эргэлт /Number of patient per bed per year	36.5	39.0
Орны фонд ашиглалтын хувь /Percentage of bed fund	78.4	83.6
Хүний нөөц/ Human resources		
10000 хүн ам ногдох эмч /Doctors per 10000 population	35.4	48.2
10000 хүн амд ногдох сувилагч /Nurses per 10000 population	39.1	45.9
10000 хүн ам ногдох эмнэлгийн мэргэжилтэн /Health professionals per 10000 population	24.8	18.9
Эмч/ сувилагчийн харьцаа /Ratio doctors/nurses	1:1.1	1:0.95
Нэг эмчид ногдох хүний тоо /Number of population per physician	283	208
Эрүүл мэндийн байгууллага/ Health organizations		
Нийт ЭМБ /Total health organizations	4343	2617
Үүнээс: Өрхийн эрүүл мэндийн төв /Family health centres	219	133
Тосгоны эрүүл мэндийн төв /Village health centres	19	4
ХХЭМБ /Private organizations	3634	2419

* Суурин хүн амын тоо / Resident population



БҮЛЭГ I. ХҮН АМ

1.1. ХҮН АМ

Монгол улс 1 сая 564.1 мян.км² нутаг дэвсгэртэй, нутаг дэвсгэрийн хэмжээгээр дэлхийд 19 дүгээр байранд, хүн амын тоогоор 137 дугаар байранд орж байна. Хүн амын тоо 2018 оны жилийн эцсийн байдлаар 3 сая 238.4 мянга болж, өмнөх оноос 60.5 мянган хүнээр буюу 1.9 хувиар өслөө. Нийт хүн амын 67.8 хувь нь хот суурин газар, 32.2 хувь нь хөдөө амьдарч байна.

Хүн амын 49.2 хувийг эрэгтэйчүүд, 50.8 хувийг эмэгтэйчүүд эзэлж байгаа ба хүйсийн харьцаа буюу 100 эмэгтэйд ногдох эрчүүдийн тоо 97 байна. 894.5 мянган өрх амьдарч байгаа ба дунджаар 1 өрхөд 3.6 хүн ногдож байна.

Улаанбаатар хотын 4,704.4 км² нутаг дэвсгэрт нийт хүн амын 46.1 хувь нь оршин сууж байна. 2018 оны байдлаар Улаанбаатар хотын суурин 1.444.6 хүн ам 9 дүүрэгт оршин сууж байгаа ба өмнөх оноос 27.2 мянган хүнээр буюу 1.9 хувиар өслөө.

Нийслэлийн хүн амын 48.4 хувийг эрэгтэйчүүд, 51.6 хувийг эмэгтэйчүүд эзэлж байгаа ба хүйсийн харьцаа 100 эмэгтэйд 94 эрэгтэй ногдож байна.

Насны бүтцээр авч үзэхэд 15 хүртэлх насны хүүхэд 31.4 хувийг, 15-19 насны хүүхэд 6.0 хувийг, 20-64 насны хүн ам 58.6 хувийг, 65 дээш насны хүн ам 4.0 хувийг тус тус эзэлж байна.

Улаанбаатар хотод 100-аас дээш настай 29 өндөр настан амьдарч байгаагаас 17.2 хувь нь эрэгтэй, 82.8 хувийг эмэгтэй ахмад настан эзэлж байна.

2018 оны байдлаар 387.4 мянган өрх амьдарч байгаа ба дунджаар 1 өрхөд 3.7 хүн ногдож байна.

CHAPTER I. POPULATION

1.1. POPULATION

Mongolia ranks at 19th in the world by its 1 million 564.1 thousand sq.meters land size and at ranks 19th in the world. Mongolia ranks at 137 for its population in the world.

By the end of 2018, population of Mongolia reached 3 million 238.4 thousand, indicating an increase of 60.5 thousand people or 1.9% compared to the previous year. Of the total population, 67.8% lives in the urban area and the remaining 32.2% resides in the rural area.

49.2% of the total population are males, whereas 50.8% are females. The sex ratio is 97 males per 100 females. There are 894.5 thousand households living in the city and in average 3.6 persons living per one household.

46.1% of the total population is residing in the territory of Ulaanbaatar with the land size of 4,704.4 sq.meters. As of 2018, 1,444.6 habitants are living in the 9 districts of Ulaanbaatar city, indicating an increase of 27.2 thousand people or 1.9% in comparison to the previous year.

Of the total urban population, 48.4% are males, whereas 51.6% are females and that makes the sex ratio to 94 males per 100 females.


According to the age structure, 31.4% are children under age 15, 6.0% are children ages of 15-19, 58.6% are ages of 20-64, and 4.0% are people above 65 years old.

In Ulaanbaatar city, there are 29 people with age above 100 from which 17.2% are males and 82.8% are females.

As of 2018, 387.4 thousand households live in average 3.7 persons per household.




Улаанбаатар хотын суурин хүн амын тоо, сонгосон оноор, сая.хүн
Resident population by UB city, by selected years, million




Улаанбаатар хотын суурин хүн ам, дүүргээр, 2018 он

Population of UB city, by district, 2018



Улаанбаатар хотын өрхийн тоо, дүүргээр, 2018 он

The number of households UB city, by district, 2018



1.2. ХҮН АМ ЗҮЙН ҮЗҮҮЛЭЛТ, ДУНДАЖ НАСЛАЛТ

Цэвэр өсөлт

Улаанбаатар хотод 2009 онд 1000 хүн амд ногдох төрөлтийн түвшин 27.7 байсан бол 2018 онд 28.4 болж 0.7 пунктээр нэмэгдсэн байна.


1.2. DEMOGRAPHIC INDICATORS, AVERAGE LIFE EXPECTANCY

Growth rate

In Ulaanbaatar, birth rate per 1000 population reached 28.4 in 2018, an increase by 0.7 points compared to 2009 level which was 27.7 per 1000 population.



Хүн ам зүйн үзүүлэлт, сүүлийн 10 жилээр Selected demographic indicators, the last 10 years



Хүн ам зүйн үндсэн үзүүлэлт, сүүлийн 10 жилээр Selected demographic indicators, the last 10 years

Он/ Year	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018
Насны бүлгээр /хувиар/ /Age group (%)										
Эмэгтэйчүүдийн эзлэх хувь/ Female population (%)	51.9	52.7	52.7	52.7	52.4	52.2	51.6	52.1	52.1	51.6
0-15 хүртэлх нас/ Age up to 0-15	25.3	25.1	25.1	27.6	26.8	26.8	29.7	29.4	29.9	31.4
15-64 нас/ 15-64	70.5	71	70.9	68.4	69.3	69.1	66.4	66.7	66.1	64.6
65-аас дээш/ Over 65	4.2	3.9	4.1	4.1	3.9	4.0	3.8	3.9	4.0	4.0
Хүн ам зүйн коэффициентууд/ Demographic rates										
ТЕК/ CBR	27.7	26.6	26.8	28.6	29.9	30.6	30.2	27.5	27.4	28.4
НБЕК/ CDR	5.9	6.6	6.2	6.0	5.5	5.5	5.4	5.1	5.2	5.7
Цэвэр өсөлт/ Growth rate	21.8	20.0	20.6	22.6	24.3	25	24.9	23.7	22.3	22.7



Хүн ам зүйн үзүүлэлт, дүүргээр, 2018 он /Demographic indicators, by district, 2018

№	Үзүүлэлт/ Indicator	БГД/ BGD	БЗД/ BZD	СХД/ SKhD	СБД/ SBD	ХУД/ KhUD	ЧД/ ChD	НД/ ND	БНД/ BND	БХД/ BKhD	УБ дун- даж/ UB city average	Эх сур- валж/ Source
1	Газар нутгийн хэмжээ (1000 км2)/ Land area (1000 км2)	29.49	1.244.12	1.200.63	208.4	484.66	89.3	687.6	620.2	140	4.704.4	НСГ/ CSO
2	Хүн амын тоо/ Population	226869	343619	321150	145335	178919	157258	37608	29512	4399	1444669	НСГ/ CSO
Хүн амын тоо насны бүлгээр / Population distribution by age (%)												
3	0–4 нас/ 0–4	29489	42832	40866	17078	24799	18790	4397	3232	533	182016	НСГ/ CSO
	5–14 нас/ 5–14	42034	64246	60906	26757	34554	28621	7575	5596	860	271149	НСГ/ CSO
	65 дээш нас/ Over 65	10111	12407	11885	7374	7164	6699	1670	1371	200	58881	НСГ/ CSO
4	Төрөлтийн түвшин (1000 хүн амд)/ Crude birth rate, per 1000 population	23.8	23.5	22.4	20.6	28.2	23.4	23.8	22.9	22.1	28.2	НЭМГ/ UBHD
5	Нас баралтын түвшин (1000 хүн амд)/ Crude death rate, per 1000 population	4.2	4.2	4.8	5.3	4.7	5.2	8.0	4.9	6.8	5.7	НЭМГ/ UBHD
6	Цэвэр өсөлт/ Growth rate	19.6	19.3	17.6	15.3	23.5	18.2	15.8	18	15.3	22.5	НЭМГ/ UBHD
7	Төрөлтийн тусгай коэффициент (15-49 насны эмэгтэйчүүд)/ Age specific total fertility rate (women aged 15-49)	82.5	82.7	83.9	72.4	95.7	88.6	92.1	86.4	84.1	103.5	НЭМГ/ UBHD

Дундаж наслалт

Төрөлтөөс тооцсон дундаж наслалт нь хүний хөгжлийн индексийн бүрэлдэхүүн хэсэг бөгөөд 2018 оны байдлаар Монгол улсын хүн амын дундаж наслалт нь 70.19 болж өмнөх оноос 0.3-аар нэмэгдэж, эмэгтэйчүүдийн дундаж наслалт 75.78, эрэгтэйчүүдийн дундаж наслалт 66.11 болсон байна.

Дундаж наслалтын хувьд хүйсийн ялгаа аль ч улс оронд байдаг ба эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс дунджаар 4 насаар илүү бөгөөд манай улсын хувьд 9.67 жилээр, Улаанбаатар хотын хувьд 8.22 жилээр илүү байна.

Average life expectancy

The average life expectancy at birth is the component of human development index and as of 2018, the average life expectancy of Mongolian population is 70.19 which is an increase of 0.3% compared to the previous year. Accordingly, average life expectancy of females is at 75.78 and males at 66.11.


The difference in average life expectancy between /males and females exist in any country. Females usually live 4 more years than males. In Mongolia, females live 9.67 years longer and in Ulaanbaatar city females live 8.22 years longer than males.



2018 оны байдлаар дэлхийн улс орнуудын хүн амын дундаж наслалтаас харахад Хонгконг улс 84.46 жил байгаа нь хамгийн өндөр, Свазиланд улсад 48.84 жил байгаа нь хамгийн бага дундаж наслалттай байна. Манай улс 129-рт бичигдсэн байна.

As of 2018, if we look at average life expectancy of world population, the highest is in Hong Kong with 84.46, and lowest in Swaziland with 48.84 years. Mongolia ranks at 129 th by the average life expectancy.

Хүн амын дундаж наслалт дэлхийн улс орнуудаар, 2018 он
Average life expectancy, by country the world, 2018



Хүн амын дундаж наслалт, эхний 10 байранд байгаа орнуудын жагсаалт
Average life expectancy, list of the first ten countries

№	Улс / хот Country / city	Дундаж наслалт /Average life expectancy	Мэдээлэл тавигдсан хугацаа /Year
1	Гонконг /Hong Kong	84.46	2017
2	Япон /Japan	83.99	2017
3	Итали /Italy	83.68	2017
4	Сингапур /Singapore	83.60	2017
5	Швейцар /Switzerland	83.49	2017
6	Испани /Spain	83.12	2017
7	Исланд /Iceland	83.05	2017
8	Израйл /Israel	82.93	2017
9	Австрали /Australia	82.90	2017
10	Франц /France	82.74	2017

Эх сурвалж: ДЭМБ цахим хуудас / Source: WHO

Улаанбаатар хотын хүн амын дундаж наслалт 71.65 үүнээс эрэгтэйчүүдийн дундаж наслалт 66.83, эмэгтэйчүүдийн дундаж наслалт 75.05 байгаа нь эрэгтэйчүүдийн амьдрах хугацаа эмэгтэйчүүдийнхээс 8.22 жилээр бага байна.

The average life expectancy in Ulaanbaatar city is at 71.65 with males at 66.83 and females at 75.05. This number shows that males live 8.22 years shorter than females.



Аливаа улсын хүн амын дотор залуу насны хүн амын эзлэх хувь их байвал хүн ам зүйн шинжлэх ухаанд залуу хүн амтай улс гэж үздэг. Ихэнх хөгжиж байгаа орнуудад хүн амын бараг хагас нь 15-аас доош насныхан, 10-15 орчим хувь нь 65 буюу түүнээс дээш насныхан байдаг.

Манай орны хувьд 2018 оны байдлаар 15-аас доош насныхан 31.2 хувь, 65 буюу түүнээс дээш насныхан 4.1 хувийг эзэлж байгаа бол Улаанбаатар хотын хувьд 15-аас доош насныхан 31.4 хувь, 65 буюу түүнээс дээш насныхан 4.0 хувийг эзэлж байна.

Хүн амын нас, хүйсийн суварга

Хүн амын нас, хүйсийн суварга нь цаг хугацааны тодорхой үеийн хүн амын нөхөн үржихүйн тасралтгүй процессын явцыг харуулна. Хэрэв хүн амын нөхөн үржихүйн процессын тухайлбал төрөлт, нас баралтын түвшинд ямар нэг өөрчлөлт гараагүй тохиолдолд насны суварга нь тэнцүүхэн дүрслэгдэх ба урт хугацааны туршид төрөлтийн өндөр түвшин хадгалагдаж, нас баралтын түвшин ч харьцангуй өндөр байсан тохиолдолд суваргын суурь нь өргөн, орой руугаа нарийссан хэлбэртэй, харин төрөлт, нас баралтын түвшин бага байсан тохиолдолд суурь нь нарийхан, орой руугаа өргөссөн хэлбэртэй байна.

According to the population studies, countries with predominantly youth is considered as the country with young population. Almost half of the population in most developing countries is under-fifteen year olds, 10-15% is over 65 and above year olds.


For Mongolia, in 2018, cohorts under- fifteen years old accounted for 31.2% and 65 years old accounted for 4.1%. For Ulaanbaatar city, cohorts under-fifteen year olds accounted for 31.4% and 65 and above year olds accounted for 4.0%.

Age and gender pyramid of the population


The age and gender pyramid demonstrates the continuous reproduction process of the population in specific period. If there is no visible change in the reproduction process of population such as birth and death rate, the age pyramid is depicted equally.

However, if the birth rate and death rate are high, the base of the pyramid will widen, becoming thinner on the top over the long run; if the birth and death rate is low, pyramid will look narrow on the base and wider on the top.

Нас, хүйсийн суварга, 2009 он
Population pyramid, 2009



Нас, хүйсийн суварга 2018 он
Population pyramid, 2018





2009 болон 2018 оны хүн амын нас, хүйсийн суваргыг харьцуулахад 2009 онд харьцангуй пирамид хэлбэртэй байхад 2018 оны суварга нь дунд хэсгээрээ аажмаар өргөсөж байгаа нь Улаанбаатар хотын хүн амын дийлэнх нь идэр насны хүн ам эзэлж, хөдөлмөрийн насны хүн ам нэмэгдэж хүн ам зүйн цонх үе үргэлжлэхийг харуулж байна. Сүүлийн жилүүдэд төрөлт тогтвортой нэмэгдэж 0-4 насны хүн ам их байгаа нь суурь өргөн бүтэцтэй байгааг харуулж байна.

1.3 ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ

Тогтвортой Хөгжлийн Зорилтууд нь олон улсын хөгжлийн талаар ирээдүйд биелүүлэхээр санал болгон дэвшүүлж буй багц зорилтууд буюу 2015 онд хэрэгжилтийн хугацаа нь дуусгавар болсон Мянганы хөгжлийн зорилтын үргэлжлэл бөгөөд 2015 оны 9-р сард НҮБ-ын дээд хэмжээний 70 дугаар чуулганаар 2030 он хүртэлх Тогтвортой хөгжлийн 17 зорилго, 169 зорилтыг баталсан.

Монгол Улсын Их Хурлын 2016 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн 19 дүгээр тогтоолоор “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-ыг батлан гаргасан байна. Монгол Улсын урт хугацааны тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг 2016-2020, 2020-2025, 2025-2030 он гэсэн гурван үе шаттайгаар хэрэгжүүлэх юм.

Тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг хэрэгжүүлснээр 2030 он гэхэд Монгол Улс ядуурлын бүх төрлийг эцэс болгож, монгол хүний эрүүл, урт удаан амьдрах нөхцөлийг ханган дундаж наслалтыг 78-д хүргэнэ, хүний хөгжлийн өндөр үзүүлэлт бүхий улс орнуудын эгнээнд багтаж, эхний 70 орны нэг болно гэж тооцсон байна.

Тогтвортой хөгжлийн 17 зорилгын 3 дахь зорилго нь “Эрүүл амьдралыг хангах” буюу бүх түвшинд эрүүл амьдралыг хангаж, сайн сайхан аж байдлыг хөхүүлэн дэмжих зорилго тавьсан байна.

If we look at the comparison of age and gender demonstration of the population between 2009 and 2018, in the former the diagram had relatively pyramid-like shape whereas in the latter year, diagram's shape shows gradual widening in the middle. This shows that the majority of the population in Ulaanbaatar city are youth and are in labour-force age and demographic window will continue. In the recent years, the number of birth has been steadily increasing, and total number of children aged 0-4 was higher which indicates the birth rate was high and eventually shows up on the diagram as the wider base.

1.3 SUSTAINABLE DEVELOPMENT

The Sustainable Development Goals (SDGs) are set of development goals for the global development to be achieved for the next decade and a half as a continuation of Millennium Development Goals. The agenda for SDGs was approved by the United Nations General Assembly during its 70th High-Level Meeting in September 2015, consists of 17 goals and 169 targets to achieve by the year of 2030.

Mongolia has articulated its development vision in “Concepts of Mongolian Sustainable Development-2030”, which was approved by the 19th Resolution of State Great Khural (Parliament) of Mongolia on 5 February, 2016. Mongolia's Sustainable Development Vision-2030 to be implemented by three phases: 2016-2020, 2020-2025 and 2025-2030.

By 2030, Mongolia would achieve the following targets through implementation of the Sustainable Development Vision such as end poverty in all its forms, improve the living environment of the Mongolian people to lead a healthy and long life; increase life expectancy at birth to 78 years and be placed among first 70 countries on the ranking of countries by the human development index.

Out of 17 SDGs, goal 3 focused on health, aimed at ensuring healthy lives and promoting well-being for all at all ages.



Зорилт 1. Урьдчилан сэргийлэх үндэсний тогтолцоог бүрдүүлэн, оношилгоо үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, хүн амын дундаж наслалтыг уртасгана.

Эрүүл мэндийн даатгалын тогтолцоог шинэчилж, урьдчилан сэргийлэх, зонхилон тохиолдох өвчнийг эрт илрүүлэх, хариу арга хэмжээг чанартай, хүртээмжтэй зохион байгуулах, тандалт, эрт илрүүлэлтийн тогтолцоо, лавлагаа лабораторийг бэхжүүлж, хүн амын дундаж наслалтыг 2020 он гэхэд 71-д хүргэх, 2025 онд 74, 2030 он гэхэд 78-д хүргэнэ гэж заасан байна.

Зорилт 2. Нөхөн үржихүйн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг дэмжих замаар сэргийлж болох эх, хүүхдийн эндэгдэлд нөлөөлөх хүчин зүйлийг багасгаж, эх, хүүхдийн эндэгдэл, хоол тэжээлийн дутагдлыг тогтвортой бууруулна.

Objective 1. Create national disease preventable system, increase the access to diagnosis services and increase life expectancy of the population.

Reform the health insurance system, ensure early diagnosis and urgent responses to preventable and predominant diseases, improve the capacity of investigation, establish early diagnosis systems and laboratories, and increase life expectancy of the population to 71 years by 2020, to 74 years by 2025 and to 78 years by 2030.

Objective 2. Reduce factors affecting preventable maternal and child mortality by improving the quality and accessibility of reproductive health care services, and decrease maternal and child mortality and malnutrition. Under this objective the following targets were set:

Эхийн эндэгдлийн түвшин (100 000 амьд төрөлтөд), сонгосон онуудаар
Maternal mortality rate (per 100 000 live births), by selected years

Үзүүлэлт Indicator	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2020	2025	2030
Улсын дундаж/ Country average	81.4	45.5	48.2	50.8	42.6	30.6	26.0	48.6	26.9	27.1	25.0 ^a	20.0 ^a	15.0 ^a
УБ хот/ UB average	78.9	46.2	44.2	43.0	52.3	35.9	28.8	41.8	31.2	29.5	-	-	-
Аймгийн дундаж/ Aimag average	83.5	44.9	51.8	58.6	32.8	25.0	23.0	56.0	22.3	24.4	-	-	-

Эх үүсвэр: а. Монгол Улсын Их Хурлын тогтоол 19, “Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030” батлах тухай, 2016 / Source: а. Resolution No 19, State Great Khural, Mongolia “Approving Mongolia Sustainable Development Vision-2030”, 2016



**Нялхсын болон 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлтөд),
Infant and under-five mortality per 1000 live births, by selected years**

Үзүүлэлт Indicator	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2020	2025	2030
Нэг хүртэлх насны хүүхдийн эндэгдэл, 1000 амьд төрөлтөд Infant mortality rate, per 1000 live birth													
Улсын дундаж/ Country average	20.2	19.4	16.3	15.3	14.6	15.3	15.3	16.8	13.6	13.4	13.0 ^a	11 ^a	8 ^a
УБ хот/ UB average	18.0	16.1	13.3	13.1	13.6	15.0	14.7	15.0	12.7	13.6	-	-	-
Аймгийн дундаж/ Aimag average	21.9	22.1	19.2	17.5	15.7	15.7	15.9	18.8	14.5	13.1	-	-	-
5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл /1000 амьд төрөлтөд Under-five mortality /per 1000 live births													
Улсын дундаж/ Country average	23.6	24.6	20	18.7	18.0	18.4	18.3	20.8	16.7	16.9	15 ^a	12 ^a	9 ^a
УБ хот/ UB average	21.0	20.6	16.2	16.0	16.3	17.8	17.3	18.2	15.4	16.1	-	-	-
Аймгийн дундаж/ Aimag average	25.7	28.0	23.5	21.3	19.7	19.0	19.2	23.7	18.1	17.7	-	-	-

Эх үүсвэр: а. Монгол Улсын Их Хурлын тогтоол 19, “Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030” батлах тухай, 2016 /Source: а. Resolution No 19, State Great Khural, Mongolia “Approving Mongolia Sustainable Development Vision-2030”, 2016

Зорилт 3. Зонхилон тохиолдох халдварт бус өвчин, тэдгээрийн эрсдэлт хүчин зүйлийн тархалт болон сэргийлж болох нас баралтыг хувь хүн, гэр бүл, хамт олон, байгууллагын идэвхтэй, оролцоотой нэгдмэл үйл ажиллагаанд тулгуурлан бууруулна.

Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулж, 10 000 хүн амд ногдох зүрх, судасны өвчлөлөөс шалтгаалсан нас баралт, хорт хавдраас шалтгаалсан нас баралтыг бууруулах.

Objective 3. Reduce the main non-communicable diseases, reduce health risk factors, and preventable deaths through an active and inclusive partnership of individuals, families, communities and organizations.

Improve the quality of and access to health care services and decrease deaths per 10,000 populations caused by cardiovascular diseases and cancer respectively.

Үзүүлэлт Indicator	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2020	2025	2030
Зүрх судасны тогтолцооны өвчлөлийн шалтгаант нас баралт, 10000 хүн амд													
Улсын дундаж/ Country average	21.7	23.6	22.6	20.9	19.6	19.1	18.8	17.5	17.4	18.9	17.4 ^a	16 ^a	14 ^a
УБ хот/ UB average	18.7	21.7	21.8	17.7	18.5	16.3	15.1	14.6	14.8	16.5	-	-	-
Хорт хавдрын нас баралт, 10000 хүн амд													
Улсын дундаж/ Country average	11.9	13.1	12.7	12.6	13.0	13.5	13.6	13.4	13.0	13.6	10.5 ^a	9 ^a	8 ^a
УБ хот/ UB average	11.7	13.5	16.4	12.7	12.7	12.3	12.1	12.8	12.5	14.1	-	-	-

Эх үүсвэр: а. Монгол Улсын Их Хурлын тогтоол 19, “Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030” батлах тухай, 2016 /Source: а. Resolution No 19, State Great Khural, Mongolia “Approving Mongolia Sustainable Development Vision-2030”, 2016



Зорилт 4. Халдварт өвчний тандалт, сэргийлэлт, бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээг уян хатан, шуурхай зохион байгуулах чадавхыг тогтвортой бэхжүүлж, нэн шаардлагатай вакциныг хүн бүрд хүртээмжтэй болгож, зонхилон тохиолдох халдварт өвчний тархалтыг бууруулна.

Objective 4. Decrease the spread of communicable diseases through prevention, early detection of communicable diseases, and preparedness to treat them, through improving the capacity of health services for fast response actions, and ensuring access to extremely necessary vaccines for everyone.

Сүрьеэ болон вируст гепатитийн өвчлөл, 10000 хүн амд, сонгосон онуудаар
Tuberculosis, viral hepatitis incidence, per 10000 population, by selected years

Үзүүлэлт Indicator	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2020	2025	2030
Сүрьеэгийн өвчлөл, 10000 хүн амд Tuberculosis, per 10000 population													
Улсын дундаж/ Country average	15.6	15.3	14.3	13.9	14.2	14.1	14.1	13.1	12.4	11.0	14.4 ^a	14 ^a	13 ^a
УБ хот/ UB average	22.8	21.5	20.1	19.1	19.7	20.4	19.7	18.6	16.6	14.1	-	-	-
Вируст гепатитийн өвчлөл, 10000 хүн амд Viral hepatitis, per 10000 population													
Улсын дундаж/ Country average	25.3	33.0	52.7	24.1	8.8	3.9	2.9	1.8	1.7	1.5	3 ^a	2.5 ^a	2 ^a
УБ хот/ UB average	23.8	24.2	42.0	23.0	9.9	4.9	4.1	2.6	2.4	2.0	-	-	-

Эх үүсвэр: а. Монгол Улсын Их Хурлын тогтоол 19, “Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030” батлах тухай, 2016 /Source: а. Resolution No 19, State Great Khural, Mongolia “Approving Mongolia Sustainable Development Vision-2030”, 2016



БҮЛЭГ II. ЭХ ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЗҮҮЛЭЛТ

2017 онд Монгол улсын Засгийн газрын 78 дугаар тогтоолоор “Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд хөтөлбөр”-ийг 2017-2021 он хүртэл хэрэгжүүлэхээр баталсан.

Хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2017-2021 онуудад Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийг сайжруулах нийгэм, эдийн засгийн таатай орчинг бүрдүүлэн хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны санхүүгийн тогтвортой байдлыг бэхжүүлж, иргэдийн болон иргэний нийгмийн оролцоог хангах замаар эрүүл мэндийн хүртээмжтэй, чанартай тусламж, үйлчилгээг бүх нийтэд тэгш хүргэснээр эх, хүүхдийн эндэгдлийг тогтвортой бууруулах юм.

2.1. ЖИРЭМСНИЙ ХЯНАЛТ, ТӨРӨХИЙН ӨМНӨХ ҮЕИЙН ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ

Төрөхийн өмнөх эрүүл мэндийн тусламж үйлчилгээ нь жирэмснийг эрт илрүүлж, жирэмсэн эмэгтэйчүүдийг жирэмсний эрт үед хяналтад авч, жирэмсний хугацаанд 6 ба түүнээс дээш удаа эмчийн хяналтад хамруулах, жирэмсэн эхчүүдийг цусны ерөнхий шинжилгээ, БЗДХ-ын шинжилгээнд бүрэн хамруулах нь цус багадалт, жирэмсний хожуу хордлого, бөөрний эмгэг, ургийн болон бусад эмгэгийг эрт илрүүлж, жирэмслэлт төрөлтийн хүндрэлээс сэргийлэх, хүндрэлийг эрт илрүүлж цаг алдалгүй эмчлэх, хавсарсан өвчнийг оношлох, эмчлэх мөн жирэмсний болон төрөх үеийн хүндрэлийг бууруулахад чиглэгдэж байна.

2.1.1. Жирэмсний хяналт

2018 оны жилийн эцсийн байдлаар НЭМГ-ын харьяа эмнэлэг, төвд жирэмсэн эмэгтэйчүүдийн 88.5 хувь нь жирэмсний эхний 3 сартайд, 10.3 хувь нь 4-6 сартайд, 1.2 хувь нь 7 ба түүнээс дээш сартайд хяналтад хамрагдсан байна.

Жирэмсний эрт хяналтын хувь 88.5 болж, өмнөх оноос 1.4 хувиар нэмэгдэж аймаг, улсын дунджаас 0.4–0.8 хувиар дээгүүр үзүүлэлттэй байна.

CHAPTER II. MATERNAL AND CHILD HEALTH INDICATORS

The Government of Mongolia has approved a “National program on maternal, child and reproductive health” by the Government Resolution No.78.

Implementation of the program during 2017-2021, to reduce maternal and child mortality by ensuring to create a favorable social and economic environment, strengthening financial stability of the program, and enhancing an active and inclusive partnership of citizens and civil society organizations for improving the quality and accessibility of health care services for all.

2.1. PRENATAL AND ANTENATAL CARE AND SERVICES

Prenatal and antenatal care services include consultations and screening for the pregnancy, following up pregnant women at least 6 times during their pregnancy, blood-testing and STI testing.

These steps can help to diagnose anemia, complications during the late period of pregnancy, kidney infections, fetus disorder or other abnormalities and to provide timely treatment preventing and reducing pregnancy and delivery's complications.


2.1.1. Antenatal care services

As of 2018, 88.5% of the pregnant women attended the antenatal care within the first trimester or first three months, 10.3% at the 4-6 months, and 1.2% at the 7 months or later in the affiliated health centers and hospitals of Ulaanbaatar city Health Department.

Percentage of early antenatal care services reached to 88.5% which is a 1.4% of increase compared to the previous year and it is 0.4-0.8% higher than the aimag and country average.



Жирэмсний эрт хяналтын хувь, дүүргээр, 2017-2018 он
Early antenatal care services, by district, 2017-2018



НЭМГ-ын харьяа эмнэлэгт хяналтад хамрагдсан нийт жирэмсэн эмэгтэйчүүд 100 хувь цусны шинжилгээнд хамрагдсан ба 2.7 хувь нь цус багадаалттай байгаа нь улсын дунджаас /3.4/ 0.7-оор, аймгийн дунджаас /4.0/ 1.3-аар тус тус бага байна.

Шинээр хяналтад хамрагдсан жирэмсэн эмэгтэйчүүдээс 99.5 хувь нь БЗДХ, вируст гепатит В,С илрүүлэх, 86.4 хувь нь рентген шинжилгээнд тус тус хамрагдсанаас 1.9 хувьд нь тэмбүү, 0.2 хувьд нь заг хүйтэн, 1.4 хувьд нь трихомониаз, 0.1 хувьд нь идэвхтэй сүрьеэ, 1.8 хувьд нь вируст гепатит В, 1.1 хувьд нь вируст гепатит С тус тус илэрсэн байна.

2018 оны байдлаар улсын хэмжээнд нийт төрсөн эхчүүдийн 84.3 хувь нь жирэмсний хугацаандаа 6 ба түүнээс дээш удаа үзүүлж хяналтад байж төрсөн бол Улаанбаатар хотод төрсөн эхчүүдийн 91.9 хувь нь, НЭМГ-ын харьяа эмнэлгүүдэд төрсөн эхчүүдийн 97.0 хувь нь жирэмсний хугацаандаа 6 ба түүнээс дээш удаа үзүүлж хяналтад хамрагдсан байна. Өмнөх онтой харьцуулахад 1.8 хувиар буурсан, улсын дүнгээс 12.7 хувиар дээгүүр үзүүлэлттэй байна.


100.0% of the total pregnant women received antenatal care in the affiliated organizations of UBHD had blood-testing and 2.7% of them were diagnosed with anemia. This figure is 3.4% /0.7/ lower than the country average and 4.0% /1.3/ lower than the aimag average.

Out of all pregnant women who newly attended antenatal care, 99.5% underwent STI testing, Viral hepatitis B and C, 86.4% had X-Ray testing and 1.9% of them identified to have syphilis, 0.2% had gonorrhea, 1.4% had trichomoniasis, 0.1% had active tuberculosis, 1.8% had viral hepatitis B, and 1.1% had viral hepatitis C.

As of 2018, 84.3% of all mothers within the nation had at least 6 times of follow up examination during their pregnancy whereas 91.9% of all mothers who gave birth within the city and 97.0% of women who gave birth in the affiliated organizations of Ulaanbaatar city Health Department had at least 6 times of follow up check-up. This figure was 1.8% lower compared to the previous year and 12.7% higher than the country.



Жирэмсний хугацаандаа 6 ба түүнээс дээш удаа хяналтад хамрагдсан эмэгтэйчүүдийн хувь, дүүргээр, 2018 он
Percentage of women underwent antenatal check-ups more than 6 times during pregnancy, by district, 2018



2.2. ТӨРӨЛТ, ТӨРӨХ ҮЕИЙН ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ

Эх, хүүхдийн эрүүл мэндийг дэмжих төрөөс баримталж буй бодлого салбарын тэргүүлэх чиглэл болоход олон талт арга хэмжээг авч хэрэгжүүлсний үр дүнд төрөлт нэмэгдэж, тусламж үйлчилгээ сайжирсаар байна.

2018 онд Улсын хэмжээнд 77058 эх төрсөн нь өмнөх оноос 3174 төрөлтөөр буюу 4.3 хувиар, Улаанбаатар хотод 40373 эх төрж өмнө хонтой харьцуулахад төрөлт 2258 тохиолдлоор буюу 5.9 хувиар тус тус нэмэгдсэн байна.

2018 онд Улаанбаатар хотод хөдөө, орон нутгаас 7423 эх ирж төрсөн нь нийт төрөлтийн 18.4 хувийг эзэлж байна. Энэ нь өмнөх оноос 1458 төрөлтөөр буюу 24.4 хувиар нэмэгдсэн байна.

Гэрийн төрөлтийн 176 тохиолдол бүртгэгдсэн нь нийт төрөлтийн 0.4 хувийг эзэлж байгаа ба өмнөх оны үзүүлэлтээс 13 тохиолдлоор буюу 8.0 хувиар нэмэгдсэн. Гэрийн төрөлтийн нийт тохиолдлын 37.5 хувь нь хөдөө орон нутгийн, 62.5 хувь нь УБ хотын харьяалалтай иргэд эзэлж байна.

2.2. LABOR AND BIRTH MEDICAL CARE AND SERVICES

The Government of Mongolia (GOM) prioritized and formulated policy supporting maternal and child health. As a result of these multifaceted activities the birth rate has increased as well as delivery of maternal care and service.

In 2018, totally 77,058 mothers gave birth in Mongolia which was 3174 births or 4.3% higher than the previous year. Within Ulaanbaatar city, 40373 mothers gave births which was 2258 births or 5.9% higher than the previous year.

In 2018, totally 7,423 mothers migrated from the countryside to the Ulaanbaatar city to give birth which accounted for 18.4% of the total births. This figure is 1458 births or 24.4% higher compared to the previous year.

Out of all births, 176 home births were registered which accounted for 0.4% of the total births and is 13 cases or 8.0% higher compared to the previous year. Of all home births, 37.5% were inhabitants of rural area and 62.5% were citizens of Ulaanbaatar city.



Төрөлтийн тоо, эрүүл мэндийн байгууллагаар, 2018 он
Number of the birth, by the types of hospitals, 2018


Эмнэлгүүд /Hospital name	Нийт төрөлт/ Total number of births	Гэрийн төрөлт/ Home births	Хөдөөгөөс ирж төрсөн эхчүүд/ Mothers from countryside to give birth in UB	Мэс заслын аргаар төрүүлсэн хувь/ Mothers underwent C-section	Эмнэлгийн мэргэжилтэн эх барьсан хувь/ Percentage of labor attended by medical professionals
Өргөө амаржих газар /"Urguu" maternity hospital	11753	38	131	35.2	99.9
Хүрээ амаржих газар /"Khuree" maternity hospital	4339	10	99	29.8	99.8
Амгалан амаржих газар /"Amgalan" maternity hospital	8433	36	113	26.5	99.8
Багануур ЭМТ /Health center of Baganuur district	688	1	139	21.5	100.0
Налайх ЭМТ /Health center of Nalaikh district	718	4	67	22.6	99.9
ЭХЭМҮТ /National center for mother and child	12478	87	6757	26.9	99.9
Хувийн эмнэлэг /Private hospital	1953	0	117	42.3	100.0
ХӨСҮТ /National center for communicable diseases	9	0	0	33.3	100.0
Тосгоны эмнэлэг /Village health center	2	0	0	0.0	100.0
Бүгд /Total	40373	176	7423	30.1	99.9

Мэдээллийн эх сурвалж: 2018 оны төрөлтийн бааз мэдээлэл / Source: Birth database, 2018

2018 онд Улаанбаатар хотод эмчийн хяналтгүй төрөлтийн 233 тохиолдол бүртгэгдсэн нь нийт төрөлтийн 0.6 хувийг эзэлж өмнөх оны мөн үеэс 13 тохиолдол буюу 5.9 хувиар нэмэгдсэн байна. Хяналтгүй төрөлтийн хувь Сүхбаатар, Багахангай дүүргээс бусад дүүрэгт УБ хотын дунджаас бага байна.


In 2018, 233 cases of births without the attendance of medical professional were registered. This figure accounted for 0.6% of all births and has increased by 13 cases or 5.9% when compared to the same period of the previous year. The percentage of unattended birth is lower than the Ulaanbaatar city average, except in Sukhbaatar and Bagakhangai district.

Хяналтгүй төрөлтийн хувь, дүүргийн байршлаар, 2017-2018 он
Delivery without antenatal care, by district, 2017-2018





Улаанбаатар хотод хөдөө, орон нутгаас ирж төрсөн эхчүүд, бодит тоо, 2017-2018 он
Number of mothers from countryside to give birth in Ulaanbaatar, 2017-2018




Нийт төрөлтийн 30.1 хувь нь мэс заслын аргаар төрсөн байна. ДЭМБ-ын зөвлөснөөр нийт төрөлтийн 5-15 хувь нь мэс заслын аргаар төрүүлж болно гэж үздэг байна. Улаанбаатар хотын хувьд 30.1 хувь нь мэс заслаар хүүхдээ төрүүлсэн байгаа нь өмнөх оноос 0.1 хувиар нэмэгдсэн, улсын дунджаас 4.3 хувиар, аймгийн дунджаас 9.0 хувиар тус тус их байна.

30.1% of the total births were delivered through caesarian section. According to the World Health Organization's recommendation, level of caesarian section is 5-15% from all deliveries. As for Ulaanbaatar city, the caesarian section rate was 30.1% which is a 0.1% increase compared to the previous year and this figure is 4.3% higher than the country average and 9.0% higher than the aimag average respectively.



Нийт төрөлтөд мэс заслын аргаар төрүүлсэн төрөлтийн эзлэх хувь, эрүүл мэндийн байгууллагаар, 2017-2018 он

Percentage of Caesarian section in the total number of the births, registered by health organization, 2017-2018



НЭМГ-ын харьяа Өргөө, Хүрээ, Амгалан амаржих газар, Багануур ЭМТ, Налайх ЭМТ, “Хатагтай”, “Таны төлөө бид” хувийн эмнэлэгт 26142 төрөлт буюу нийт төрөлтийн 64.8 хувь нь, ЭМЯ-ны харьяа ЭХЭМҮТ, ХӨСҮТ, Интермед, Гурван гал хувийн эмнэлэгт 14231 төрөлт буюу 35.2 хувь нь төрсөн байна.

НЭМГ-ын харьяа ЭМБ-д төрсөн эхчүүдээс анхны төрөлт 24.3 хувь, 1 жилийн зайтай төрсөн эх 5.1 хувь, 2 жилийн зайтай төрсөн эх 14.4 хувь, 3 ба түүнээс дээш жилийн зайтай төрсөн эх 56.2 хувь байна. Нийт төрөлтөд 35-аас дээш насны төрөлт 18.7 хувь, 20 хүртэлх насны төрөлт 4.0 хувийг эзэлж байна.


Төрөлтийг насны ангиллаар авч үзэхэд 20 хүртэлх насны төрөлт 4.0 хувь, 20-24 насны төрөлт 18.5 хувь, 25-29 насны төрөлт 32.6 хувь, 30-34 насны төрөлт 26.2 хувь, 35-39 насны төрөлт 14.8 хувь, 40-44 насны төрөлт 3.8 хувь, 45-49 насны төрөлт 0.2 хувийг эзэлж байгаа ба анхны төрөлт 24.3 хувь, 6 ба түүнээс дээш төрөлт 0.8 хувийг эзэлж байна.

26142 births or 64.8% of the total births have been delivered in the affiliated maternity hospitals of UBHD such as, Urguu, Khuree, Amgalan, Baganuur District Health Center, Nalaikh district Health Center, “Khatagtai” and “Tanii tuluu bid” private hospitals. 14,231 births or 35.2% of the total births were delivered in the affiliated organizations of Ministry of Health such as, National Center for Maternal and Child Health, National Center for Infectious Diseases, Intermed and Gurvan Gal.

Of deliveries, in subordinated hospitals of UB city Health Department, 24.3% were first birth, 5.1% had one year of interval, 14.4% had two years of interval, 56.2% had three or more years of interval between births. Out of all deliveries, 18.7% were mothers above 35 years old and 4.0% were mothers younger than 20 years old.

By the age group, percentage of mothers under 20 years old was 4.0%, 20-24 year olds 18.5%, 25-29 year olds 32.6%, 30-34 year olds 26.2%, 35-39 year olds 14.8%, 40-44 year olds 3.8% and 45-49 year olds 0.2%. The first birth (primipara) accounted for 24.3%, 6 or more births accounted for 0.8%.

Улаанбаатар хотод төрсөн эх, насны ангиллаар, 2018 он
Number of total birth in UB, by age, 2018



Нийт төрөлтийн 99.5 хувийг эх барих, эмэгтэйчүүдийн эмч, 0.4 хувийг их эмч, 0.1 хувийг мэргэжлийн бус хүн удирдаж төрүүлсэн байна. Төрөлтийн тусгай коэффициентийг тооцоход нөхөн үржихүйн насны 1000 эмэгтэй тутмын 83.8 нь хүүхэд төрүүлсэн байна. Энэ нь 2017 онтой харьцуулахад 3.8-аар нэмэгдсэн байна.

By the attendance of labor by medical professionals, 99.5% of them were attended by obstetrician and gynecologists, 0.4% by physicians and 0.1% by nonprofessionals. This figure demonstrates the birth level of women of reproductive age. Crude birth rate was 83.8 out per 1,000 women of reproductive age in 2018. Compared to 2017, it increased by 3.8 points.

Насны бүлэг дэх төрөлтийн коэффициент, 2018 он
Age specific fertility rate, 2018

Насны бүлэг / Age group	Тухайн насны эмэгтэйчүүдийн тоо / Number of women of reproductive age	Тухайн насны эмэгтэйчүүдийн амьд төрүүлсэн хүүхдийн тоо / Number of live births given by women of reproductive age	Насны бүлэг дэх төрөлтийн коэффициент / Age specific rate
15-19	42307	1209	28.6
20-24	48038	5876	122.3
25-29	70364	10675	151.7
30-34	76062	8959	117.8
35-39	59268	5052	85.2
40-44	52751	1357	25.7
45-49	44310	62	1.4

Энэ үзүүлэлт нь эмэгтэйчүүдийн насны бүлгүүд дэх төрөлтийн ялгавартай түвшнийг илэрхийлнэ. Насны бүлэг дотор 20-24 насны 1000 эмэгтэй тутмын 122.3 нь, 25-29 насны 1000 эмэгтэй тутмын 151.7 нь, 30-34 насны 1000 эмэгтэй тутмын 117.8 нь хүүхэд төрүүлж байгаа нь өндөр үзүүлэлттэй байна.

This figure gives an overview of levels of birth across age groups of women. Age specific fertility rates (ASFR) are the highest among 20-24 year olds with 122.3 per 1,000 women and 25-29 year olds with 151.7 per 1,000 women, 30-34 year olds with 117.8 per 1000 women.




Төрөлтийн нийлбэр коэффициентийг насны бүлэг дэх төрөлтийн коэффициентийг ашиглан тооцоход 2.7 байгаа нь нэг эмэгтэй нийт амьдралынхаа туршид дунджаар 3 хүүхэд төрүүлж буйг илэрхийлж байна.

Амьгүй төрөлтийн 264 тохиолдол бүртгэгдсэн нь өмнөх оноос 10 тохиолдлоор буюу 3.9 хувиар нэмэгдсэн байна. Амьгүй төрөлтийн 28.0 хувь нь хөдөө орон нутгийн, 72.0 хувь нь УБ хотын харьяалалтай иргэд эзэлж байна.

Total fertility rate was 2.7 which means, a woman gives birth to 3 children in average during her whole life.

264 cases of stillbirth were registered and compared to the previous year it shows a increased by 10 cases (3.9%). 28.0% of stillbirth were registered from the countryside and 72.0% recorded in UB.

Амьгүй төрөлтийн түвшин, 1000 нийт төрөлтөд, дүүргээр, 2017-2018 он
Stillbirth rate per 1000 births, by districts, 2017-2018



Амьгүй төрөлтийн түвшин Сонгинохайрхан, Хан Уул, Налайх, Багахангай дүүрэгт хотын дунджаас өндөр байна.

Stillbirth rate was higher in Songinokhairkhan, Khan Uul, Nalaikh and Bagakhangai district than UB average.

2.3. ТӨРСНИЙ ДАРААХ ҮЕИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ

2018 оны байдлаар НЭМГ-ын харьяа өрх, тосгоны эмчийн эмнэлгийн хяналтад байж төрсөн эхчүүдээс 92.0 хувь нь төрсний дараа 42 хоногтойдоо идэвхтэй хяналтад хамрагдсан байна. Энэ нь өмнөх оноос 6.1 хувиар буурсан бол улсын дундаж /87.5/ үзүүлэлтээс 4.5 хувиар, аймгийн дунджаас /89.5/ 2.5 хувиар их байна. Энэ нь төрсний дараах хүндрэл болон эхийн эндэгдэл буурахад чухал ач холбогдолтой үзүүлэлт юм.

2.3. POST- PARTUM HEALTH CARE SERVICES

In 2018, 92.0% of mothers who were under antenatal care received a post-partum maternal care within 42 days of birth. Although this parameter decreased by 6.1% compared to the previous year and it was higher by 4.5% and 2.5% than the country /87.5/ and aimag /89.5/ averages. This indicator is imperative in reducing a post-partum complications and maternal mortality.




2018 оны байдлаар Улаанбаатар хотын хэмжээнд жирэмсэн, төрөх, төрсний дараах үеийн хүндрэл 44982 тохиолдол бүртгэгдсэн нь өмнөх оноос 5335 тохиолдол буюу 13.5 хувиар нэмэгдсэн байна. Нийслэлийн эрүүл мэндийн газрын харьяа амаржих газар, дүүргийн эрүүл мэндийн төв, хувийн эмнэлгүүдэд жирэмсэн, төрөх, төрсний дараах үеийн хүндрэлийн нийт 29345 тохиолдол бүртгэгдэж өмнөх оноос 2876-аар нэмэгдэж, нийт УБ хотод бүртгэгдсэн хүндрэлийн 65.2 хувийг эзэлж байна.

Жирэмсэн, төрөх, төрсний дараах хүндрэлийн 28637 тохиолдол буюу 97.6 хувь нь амаржих газруудад, 707 тохиолдол буюу 2.4 хувь нь Багануур, Налайх дүүргийн эрүүл мэндийн төвд бүртгэгдсэн байна.

As of 2018, In Ulaanbaatar, 44,982 cases related to pregnancy, childbirth, post-partum complications were registered when compared to the previous year it increased by 5,335 cases or 13.5%. 29,345 cases of pregnancy, childbirth, post-partum complications were registered in subordinated maternity hospitals of UB Health Department, districts health centers and private hospitals. This number was higher than those of the previous year by 2,876 and accounted for 65.2% of registered complications in UB.

28,637 cases (97.6%) of pregnancy, childbirth, post-partum complications were reported by maternity hospitals, 707 were reported (2.4%) by Baganuur, Nalaikh Districts Health Centers.

Жирэмсэн, төрөх, төрсний дараах үеийн хүндрэл, хувиар, 2014-2018 он Percentage of pregnancy, childbirth and post-partum complications, 2014-2018



Жирэмсэн үеийн хүндрэл өмнөх оноос 4.9 хувиар нэмэгдсэн ба жирэмсэн үеийн хүндрэл дотор манас таталтын урьтал болон манас таталт 15.3 хувь, ихэс түрүүлэлт 1.6 хувь, ихэс цагаасаа өмнө ховхрох 0.7 хувь, даралт ихсэх 10.4 хувь, чихрийн шижин 0.4 хувь, бусад 71.5 хувийг эзэлж байна.

Pregnancy complication increased by 4.9% compared to the previous year. Those complications such as pre-eclampsia and eclampsia accounted for 15.3%, placenta previa 1.6%, placental abruption 0.7%, high-blood pressure 10.4%, diabetes 0.4% and others 71.5%.



Төрөх үеийн хүндрэл өмнөх оноос 7.1 хувиар буурсан ба ус эрт гарах 25.5 хувь, төрөх хүчний сулралт 19.8 хувь, хүүхдийн буруу байрлалаас төрөлт саатах 6.0 хувь, эхийн аарцаг ясны хөгжлийн гажгаас төрөлт саатах 3.3 хувь, хязангийн урагдалт 13.0 хувь, умайн хүзүүний урагдал 2.4 хувь, төрөх үеийн цус алдалт 0.3 хувь, ихэс түдэлт 0.4 хувь, бусад 29.2 хувийг тус тус эзэлж байна.

Төрсний дараах хүндрэл мөн үеийн түвшинд ба төрсний дараах эрт үеийн /4цаг/ цус алдалт 55.9 хувийг, хожуу цус алдалт 2.1 хувийг, төрсний дараах халдвар 4.5 хувь, бусад 37.5 хувийг тус тус эзэлж байна.

Нийт хүндрэлийн дотор 7.6 хувийг жирэмсэн, төрөхөөс үл хамаарах өвчний хүндрэл эзэлж байгаа ба өмнөх оноос 2.1 хувиар нэмэгдсэн байна.

2.4. ЭХИЙН ЭНДЭГДЭЛ

Улсын хэмжээнд 2018 оны байдлаар эхийн эндэгдлийн 21 тохиолдол бүртгэгдсэнээс 12 тохиолдол нь Улаанбаатар хотод бүртгэгдэж, 100 000 амьд төрөлтөд 29.5 болсон нь улсын дунджаас 2.4-өөр их үзүүлэлттэй байна.

Эхийн эндэгдлийн 7 тохиолдол буюу 58.3 хувь нь УБ хотын харьяалалтай байгаагаас дүүргээр авч үзвэл Баянзүрх 2, Баянгол, Сонгинохайрхан, Сүхбаатар, Хан-уул, Чингэлтэй дүүрэгт тус тус 1 эх эндсэн байна.

100000 амьд төрөлтөд ногдох эхийн эндэгдэл Сүхбаатар дүүрэгт 35.2 байгаа нь УБ хотын дунджаас 5.7-оор өндөр байна. Эхийн эндэгдэл Налайх, Багануур, Багахангай дүүрэгт бүртгэгдээгүй байна. Хөдөө орон нутгаас 41.7 хувь буюу 5 эх энджээ.

Childbirth complications decreased by 7.1% compared to the previous year, e.g., leak age of the amniotic fluid was 25.5%, secondary uterine inertia was 19.8%, failure to progress in labor due to wrong position of baby in uterus was 6.0%, failure to progress in labor due to cephalopelvic was 3.3%, perineal rupture was 13.0%, rupture of cervix was 2.4%, bleeding during the childbirth was 0.3%, placental complication was 0.4 and others were 29.2%.

Bleeding at the early period after delivery /4hours/ accounted for 55.9%, late bleeding 2.1%, post-partum infection 4.5% and others accounted for 37.5%.

7.6% of total complications were caused by disease complications not related to the delivery that compared to the previous year increased by 2.1%.

2.4. MATERNAL MORTALITY

As of 2018, 21 cases of maternal mortality were registered in Mongolia of which 12 occurred in UB. Maternal mortality rate was 29.5 per 100 000 it was live births, 2.4 higher than the country average.

Of total 12 mortality cases, 7 (58,3%) were Ulaanbaatar residents, e.i. 2 from Bayanzurkh, 1 from Bayangol, Songinokhairhan, Sukhbaatar, Khan Uul, Chingeltei districts account 1 maternal mortality each.


Maternal mortality per 100,000 live births differs by districts; Sukhbaatar (35.2) had the higher rate than the capital average by 5.7. Nalaikh, Baganuur and Bagakhangai had no maternal mortality rate. 5 (41.7%) of maternal mortality cases were residents from rural areas.



Эхийн эндэгдлийн түвшин, 100 000 амьд төрөлтөд, 2009-2018 он
Maternal mortality, per 100 000 live births, 2009-2018

Үзүүлэлт/ Indicator	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018
Эхийн эндэгдэл / бодит тоо / Maternal mortality /absolute number/										
Улс/Country	56	30	34	37	34	25	21	38	20	21
Улаанбаатар/ UB city	24	14	15	16	21	15	12	17	12	12
Эхийн эндэгдлийн түвшин /100 000 амьд төрөлтөд/ Maternal mortality /per 100 000 live births/										
Улс/Country	81.4	45.5	48.2	50.8	42.6	30.6	26.0	48.6	26.9	27.1
Улаанбаатар/ UB city	78.9	46.2	44.2	43.0	52.3	35.9	28.8	41.8	31.2	29.5


Эхийн эндэгдэл, 100 000 амьд төрөлтөд, 2009-2018 он
Maternal mortality, per 100 000 live births, 2009-2018



Улаанбаатар хотод бүртгэгдсэн эхийн эндэгдлийн 12 тохиолдлоос 2 буюу 16.7 хувийг НЭМГ-ын харьяа эмнэлэг, 10 тохиолдол буюу 83.3 хувийг ЭМЯ-ны харьяа төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүд мэдээлсэн ба эндсэн газраар нь авч үзвэл 9 эх нь эмнэлэгт, 1 эх гэртээ, 1 эх тээврийн хэрэгсэлд, 1 эх бусад газарт эндсэн байна.

Of 12 maternal mortality cases registered in UB, 2 or 16.7% were in subordinated hospitals of UB city Health Department, 10 or 83.3% were in affiliated facilities of Ministry of Health. 1 mother at home, 1 mother in a car on the way to hospital, 1 mother passed away at other places and 9 at hospitals.


Эхийн эндэгдэл, бүртгэгдсэн эрүүл мэндийн байгууллагаар, 2018 он
Maternal mortality, registered by health organization, 2018



Эндсэн эхчүүдийг насны ангиллаар авч үзвэл: 16.7 хувь нь 20-24 насны, 50.0 хувь нь 25-29 насны, 25.0 хувь нь 30-34 насны, 8.3 хувь нь 40-44 насны эмэгтэйчүүд эзэлж байна.

Ажил эрхлэлтээр нь авч үзвэл 50.0 хувь нь ажилгүй, 8.3 хувь нь ажилчин, 16.6 хувь нь ажилчин, албан хаагч, 8.3 хувь нь малчин, 25.0 хувь нь бусад тус тус эзэлж байна.

Эндсэн эхчүүд, насны ангиллаар, 2018 он Maternal mortality, by age, 2018



Эндсэн эхчүүдийн 8 буюу 66.6 хувь эх барихын шууд шалтгаантай, 4 буюу 33.3 хувь нь эх барихын шууд бус шалтгаантай эндэгдэл байна.

2.5. ЖИРЭМСЛЭЛТЭЭС СЭРГИЙЛЭХ ОРЧИН ҮЕИЙН АРГА, ХЭРЭГЛЭЭ


Жирэмслэлтээс сэргийлэх орчин үеийн арга /ЖСА/ нь хүсээгүй жирэмслэлт, хууль бус үр хөндөлт мөн төрөлт хоорондын зайг зохицуулахад чухал ач холбогдолтой юм.

2018 оны байдлаар төрөх насны эмэгтэйчүүдийн 58.3 хувь нь ЖСА хэрэглэдэг гэсэн статистик үзүүлэлт байгаа нь өмнөх оноос 3.4-өөр нэмэгдсэн байна. Нөхөн үржихүйн насны 1000 эмэгтэйчүүдийн 583 нь жирэмслэлтээс сэргийлэх ямар нэг аргыг хэрэглэж байгаа нь өмнөх оны мөн үеэс 34-өөр нэмэгдсэн байна.

Stratification of maternal mortality by age shows 16.7% 20-24, 50.0% 25-29, 25.0% 30-34, and 8.3% were aged 40-44.

Maternal deaths by mother's occupation are shown as follows; 50.0% unemployed, 16.6% employed, 8.3% herdsmen, 25.0% other.

Эхийн эндэгдлийн шалтгаан, 2018 он Maternal mortality, by causes, 2018



With regards to the cause of maternal mortality, 8 cases (66.6%) occurred due to obstetric cases and rest were (33.3%) associated with of non-obstetric conditions.

2.5. USE OF MODERN METHODS OF CONTRACEPTION

Modern methods of contraception can help to regulate unwanted pregnancy, illegal abortion and length between pregnancies.


According to the statistics, in 2018, 58.3% of women of reproductive age use contraception which is 3.4 point increase from the level in the previous year. 583 in 1,000 women of childbearing age reported as using any contraceptive methods that indicates a increase by 34 compared to the previous year.



Нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн бэлгэвчийн хэрэглээ 34.4 хувь байгаа нь өмнөх оноос 2.3 хувиар буурсан байна.

Compared to the previous year, level of condom usage among women of reproductive age decreased by 2.3 points reaching 34.4%.

Жирэмслэлтээс сэргийлэх арга, 2018 он
Contraception methods, 2018



2.6. ҮР ХӨНДӨЛТ

Улсын хэмжээнд 2018 оны байдлаар үр хөндөлтийн 15822 тохиолдол бүртгэгдэж, 1000 амьд төрөлтөд 204.0, нөхөн үржихүйн насны 1000 эмэгтэйд 18.8 үр хөндөлт ногдож байна.

Улаанбаатар хотын эмнэлэгт үр хөндөлтийн 11074 тохиолдол бүртгэгдсэн нь нийт үр хөндөлтийн 70.0 хувийг эзэлж байгаа ба 1000 амьд төрөлтөд 272.0, нөхөн үржихүйн насны 1000 эмэгтэй тутмын 28.2 нь үр хөндүүлсэн нь өмнөх оноос 1587 тохиолдол буюу нөхөн үржихүйн насны 1000 эмэгтэй тутамд 3.1-ээр буурсан байна.

ЭХЭМҮТөвд 1924 тохиолдол буюу 17.4 хувь нь, НЭМГ-ын харьяа эмнэлэгт 8937 тохиолдол буюу 80.7 хувь нь үр хөндүүлсэн байна.

2.6. ABORTION

In 2018, 15,822 cases of abortions were registered in Mongolia; 204.0 per 1000 live births, 18.8 per 1,000 women in reproductive age had abortion.

11,074 abortions were performed in hospitals of Ulaanbaatar city and it occupies 70.0 percent of total cases. Number of abortions reported to be 272.0 in 1,000 live births which means 28.2 in every 1,000 women had an abortion in 2018. The number has decreased by 1587 cases and 3.1 in 1,000 women from the level in the previous year.

1924 cases or 17.4% and 8937 cases or 80.7% of abortions were performed in NCMCH and subordinated hospitals of the UB Health Department respectively.




Үр хөндөлт, бүртгэгдсэн эрүүл мэндийн байгууллагаар, 2014-2018 он
Abortion, registered by health organization, 2014-2018

Эрүүл мэндийн байгууллага /Type of health facility	2014		2015		2016		2017		2018	
	Нийт бүртгэгдсэн үр хөндөлтийн тоо /Number of recorded abortions	20-оос доош насны үр хөндөлтийн эзлэх хувь /Percentage of the women aged under 20 who underwent abortion	Нийт бүртгэгдсэн үр хөндөлтийн тоо /Number of recorded abortions	20-оос доош насны үр хөндөлтийн эзлэх хувь /Percentage of the women aged under 20 who underwent abortion	Нийт бүртгэгдсэн үр хөндөлтийн тоо /Number of recorded abortions	20-оос доош насны үр хөндөлтийн эзлэх хувь /Percentage of the women aged under 20 who underwent abortion	Нийт бүртгэгдсэн үр хөндөлтийн тоо /Number of recorded abortions	20-оос доош насны үр хөндөлтийн эзлэх хувь /Percentage of the women aged under 20 who underwent abortion	Нийт бүртгэгдсэн үр хөндөлтийн тоо /Number of recorded abortions	20-оос доош насны үр хөндөлтийн эзлэх хувь /Percentage of the women aged under 20 who underwent abortion
ЭХЭМҮТ /NCMCh	3160	9.7	2592	7.3	2215	5.4	2027	8.4	1924	9.4
Амаржих газар /Maternity hospitals	5914	4.0	8011	4.0	8158	4.1	8340	4.1	7012	4.4
Дүүргийн ЭМТөв /District health centers	116	2.6	68	4.4	68	7.4	91	17.6	89	14.6
Хувийн эмнэлэг /Private hospitals	2703	7.1	2473	3.4	3364	3.4	2203	2.6	2049	2.5
Бусад /Other hospitals	7	0.0	20	25.0	0	0.0	0	0.0	0	0
Бүгд /Total	11900	6.2	13164	4.6	13805	4.2	12661	4.6	11074	5.0

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад үр хөндөлт 1587 тохиолдлоор буурсан байна. (1328-Амаржих газар, 2-дүүргийн эрүүл мэндийн төв, 154- хувийн эмнэлэг, 103-ЭХЭМҮТ)

Compared to previous year, abortion was reduced to 1587 cases. (328 in Maternity hospital, 2 in District Health Center, 154 in private hospitals and 103 cases in the NCMCh)

Үр хөндөлт, 1000 амьд төрөлтөд, 2009-2018 он
Abortions, per 1000 live births, 2009-2018



Үр хөндөлт 1000 амьд төрөлтөд аймгийн дунджаас 143.1-ээр, улсын дунджаас 68.0-аар тус тус өндөр байна.

Abortion rate per 1,000 live births was higher than the aimag average and country average by 143.1 and 68.0 respectively.



НЭМГ-ын харьяа эмнэлэгт үр хөндүүлсэн эмэгтэйчүүдийн 4.2 хувь нь хожуу үр хөндүүлсэн ба өмнөх оноос 0.4 хувиар нэмэгдсэн байна. Үр хөндүүлсэн эмэгтэйчүүдийн 8.2 хувь нь төрөөгүй эмэгтэйчүүд эзэлж байгаа нь өмнөх оноос 2.1 хувиар нэмэгдсэн. 20-оос доош насны үр хөндүүлсэн эмэгтэйчүүдийн хувь 4.1 болж өмнөх оноос 0.2 хувиар нэмэгдэж, улсын дунджаас 1.4 хувиар бага үзүүлэлттэй байна.

Үр хөндөлтийн 3 хүндрэлийн тохиолдол бүртгэгдсэн ба хүндрэлийн 33.3 хувийг умайн агшилт суларч цус алдсан, 33.3 хувийг умай цоорсон, 33.3 хувийг умайн дайврын үрэвсэл тус тус эзэлж байна.

2.7. ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНД

2018 оны байдлаар улсын хэмжээнд 77528 хүүхэд амьд төрсөн нь өмнөх оны мөн үеэс 3200 хүүхдээр буюу 4.3 хувиар нэмэгдсэн байна. Амьд төрсөн хүүхдийн 1760 нь 2 ихэр, 41 нь 3 ихэр хүүхэд байна.

Улаанбаатар хотод нийт 40703 хүүхэд амьд төрсөн нь өмнөх оноос 2299 хүүхдээр нэмэгдсэн байна. Нийт амьд төрсөн хүүхдийн 64.4 хувь буюу 26230 хүүхэд НЭМГ-ын харьяа амаржих газар болон хувийн эмнэлэгт төрсөн ба 51.1 хувь нь хүү, 48.9 хувь нь охин мэндэлсэн байна.

Төрөөд 1 цагийн дотор хөхөө амласан хувь 96.5 байгаа нь өнгөрсөн оноос 0.2-оор нэмэгдсэн байна. Амьд төрсөн хүүхдийн 2.8 хувь нь 2500 граммаас бага жинтэй төрж, 99.7 хувь нь БЦЖ, 99.7 хувь нь саа, 99.7 хувь нь гепатитын вакцин хийлгэсэн байна.

Амьд төрсөн нярайн 463 нь 2 ихэр, 5.1 хувь нь дутуу, 0.7 хувь нь бүтэлтэй төрсний 97.3 хувь нь амьдарч, 2.7 хувь нь нас барсан байна. Амьд төрсөн нярайн 0.5 хувьд нь төрөлхийн гажигтай нярай бүртгэгдсэн байна.

Амьгүй төрсөн 148 хүүхдийн 6.1 хувь нь 2 ихэр, 20.9 хувь нь 22-28 долоо хоногтой дутуу төрсөн нярай, 66.2 хувь нь 2500 граммаас бага жинтэй хүүхэд төрсөн байна.

4.2% of women who underwent abortion at subordinated hospitals of UB Health department had late abortion and increased by 0.4% compared to the previous year. 8.2% of the women who underwent abortion were the women who had never given birth before and compared to the previous year it increased by 2.1%. Percentage of the women aged under 20 who underwent abortion reached 4.1 and compared to the previous year it increased by 0.2%, while it was 1.4% lower than the country average.

Total of 3 cases with abortion complications were recorded. These complications of the abortion were consisted of bleeding due to weakening of uterine contractility 33.3%, an inflammation of the uterine appendages 12.5% and uterus punctured problem 33.3%, respectively.

2.7. CHILD HEALTH

In 2018, 77,528 live births were recorded in Mongolia, an increase by 3200 newborns compared to 2017. Of total live births 1760 were twins and 41 were triplets.

40,703 live births were recorded in Ulaanbaatar, an increase by 2299 newborns compared to 2017. 26,230 or 64.4% of total live births were born in subordinated maternity hospitals and private hospitals of UB Health Department; 51.1% of them were boys, 48.9% of them were girls.

Majority of newborns (96.5%) were breastfed during their first hour of life, 99.7% received BCG vaccination, 99.7% polyomyelitis vaccination and 99.7% hepatitis vaccination within 24 hours. 2.8% of newborns had birth weight under 2500 grammes.

463 of live newborns were twins and 5.1% premature babies. Asphyxia was documented in 0.7% of newborns of which 97.3% have survived and 2.7% were deceased. 0.5% of live newborns were born with congenital disorder.

6.1% of 148 stillbirths were twins, 20.9% was premature babies in 22-28 week of gestation and 66.2% had birth weight under 2,500 grammes.



Амьд төрсөн хүүхэд, бүртгэгдсэн эрүүл мэндийн байгууллагаар, 2018 он
Data on newborns, registered by health organization, 2018

Эрүүл мэндийн байгууллагууд /Type of health facility	Төрсөн хүүхэд /Total births					Амьгүй төрөлтийн түвшин (нийт 1000 төрөлтөд) /Stillbirth rate (per 1000 births)
	Бүгд /Total	Эрэгтэй /Male	Эмэгтэй /Female	Хүйсийн харьцаа /100-д/ Sex ratio	Бага жинтэй хүүхдийн эзлэх хувь/Percentage of low birth weight babies	
Амаржих газар /Maternity hospital	24610	12554	12056	104.1	2.9	5.7
Эрүүл мэндийн төв /District health center	1409	732	677	108.1	2.6	4.9
Хувийн эмнэлэг /Private hospital	209	124	85	145.9	0.5	0.0
Тосгоны эмнэлэг /Village health center	2	2	0	-	0.0	0.0
НЭМГ-ын дүн /Total from subordinated hospitals of UBHD	26230	13412	12818	104.6	2.8	6.4
Улаанбаатар / Ulaanbaatar	40703	20835	19868	104.9	5.1	6.4
Аймгийн дүн /Aimag average	36825	18952	17873	106.0	3.7	4.7
Улсын дүн /Country average	77528	39787	37741	105.4	4.4	5.6

Улаанбаатар хотод нярай хүүхдийн өвчлөлийн 15858 тохиолдол бүртгэгдсэн ба өмнөх оноос 3999-өөр нэмэгдэж, амьд төрсөн хүүхдийн 38.9 хувь нь өвчилсөн бол НЭМГ-ын харьяа эмнэлгүүдэд 3936 буюу 24.8 хувь нь бүртгэгдэж, амьд төрсөн хүүхдийн 15.0 хувь нь өвчилсөн байна. Нярай хүүхдийн өвчлөлийн аймгийн дундаж /27.2/, улсын дундаж /33.4/ байна.

Улаанбаатар хотын нярайн өвчлөлд перинаталь үед үүссэн эмгэг 84.6 хувийг эзэлж байгаа бол НЭМГ-ын харьяа эмнэлгүүдэд 84.2 байна. Үүнээс: нярайн шарлалт 46.6 хувь, төрөхөд бүтэх 5.6, перинаталь өвөрмөц бусад халдвар 4.5 хувь, нярайн амьсгалын гачаал 4.0, нярайн хүйтэс 3.3 хувийг тус тус эзэлж тэргүүлэх шалтгаан болж байна. Төрөлхийн гажгийн 585 тохиолдол бүртгэгдсэн ба өмнөх оноос 123 тохиолдол буюу 26.6 хувиар нэмэгдсэн байна.

In Ulaanbaatar, 15,858 neonatal morbidity cases were registered that points out to the increase by 3999 compared to the previous year. 38.9% of live newborns suffered from any disease; 3,936 cases or 24.8% of them were registered in subordinated hospitals of UB Health Department and 15.0% of live newborns suffered from any disease. The aimag average of neonatal morbidity was 27.2 and the country average was 33.4.

In Ulaanbaatar, conditions occurred during the perinatal period was the leading cause of infant morbidity (84.6%). The rate is 84.2% in subordinated hospitals of UBHD. Of the total neonatal 46.6% had neonatal jaundice, 5.6% birth asphyxia, 4.5% had other infection specific to perinatal period, 4.0% respiratory distress of newborn, 3.3% had newborn omphalitis. 585 cases of congenital disorder of newborns were registered. Compared to the previous year it increased by 123 cases (26.6%).



Нярай хүүхдийн өвчлөл, 2018 он
Neonatal morbidity rate, 2018

Үзүүлэлт /Indicator	Нийт өвчлөл /Total neonatal morbidity	Перинаталь үед үүссэн зарим эмгэг/Perinatal pathology	Халдварт ба шимэгчит өвчин /Infectious and parasitic diseases		Амьсгалын тогтолцооны өвчин /Diseases of respiratory system		Хоол шингээх эрхтний эмгэг /Diseases of digestive system		Төрөлх гажиг, гаж хөгжил/ Congenital abnormalities	Гадны шалтгаан/ External causes	Осол гэмтэл /Injuries	Бусад өвчин/Other diseases
			Бүгд /Total	Төрөлхийн тэмбүү/ Congenital syphilis	Бүгд/ Total	Уушгины хатгаа /Pneumonia	Бүгд/ Total	Халдварт бус суулгалт /Non-infectious diarrhea				
Аймгийн дүн /Aimag average	10016	7284	40	12	1145	395	122	77	278	2	8	1123
Улаанбаатар /Ulaanbaatar	15858	13412	22	21	678	282	140	12	585	0	5	942
Улсын дүн /Country average	25874	20696	62	33	1823	677	262	89	863	2	13	2065

2.8. НЯЛХАС БОЛОН ТАВ ХҮРТЭЛХ НАСНЫ ХҮҮХДИЙН ЭНДЭГДЭЛ

2.8. INFANT AND UNDER-FIVE CHILDREN MORTALITY RATE

Хүүхдийн эндэгдэл сүүлийн жилүүдэд тогтвортой буурч байгаа нь хөхөөр хооллолт, өргөн дархлаажуулалт, хүүхдийн өвчний цогц менежмент зэрэг нийгмийн эрүүл мэндийн оновчтой арга хэмжээг амжилттай авч хэрэгжүүлж байгаатай шууд холбоотой юм.

Continuous decline of child mortality during the last years is directly related to adequate public health measures, such as promoting breastfeeding, improved immunization coverage and comprehensive management of child morbidity.


Нялхас болон тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин, 1000 амьд төрөлтөд, сүүлийн 10 жилээр

Infant and under-five children mortality rate, per 1000 live births, by last 10 years


Үзүүлэлт /Indicator	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018
Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин /Under-five children mortality rate	21.0	20.6	16.2	16.0	16.3	17.8	17.3	18.2	15.4	16.1
Нялхсын эндэгдлийн түвшин /Infant mortality rate	18.0	16.1	13.3	13.1	13.6	14.9	14.7	15.0	12.7	13.6



Нэг хүртэлх насны хүүхдийн эндэгдэл, 1000 амьд төрсөн хүүхдэд, 2009-2018 он Infant mortality rate, per 1000 live births, 2009-2018



Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл, 1000 амьд төрсөн хүүхдэд, 2009-2018 он Under-five children mortality rate, per 1000 live births, 2009-2018



2018 оны байдлаар Улаанбаатар хотын хэмжээнд нялхсын эндэгдлийн 555 тохиолдол бүртгэгдсэн нь өмнөх оноос 66 тохиолдлоор буюу 13.5 хувиар, амьд төрсөн 1000 хүүхдэд 13.6 болж 0.9 промилиор нэмэгдсэн байна. Нялхсын эндэгдлийн 21.6 хувь нь НЭМГ-ын харьяа эмнэлгүүдэд, 78.4 хувь нь ЭМЯ-ны харьяа эмнэлгүүдэд эндсэн байна. Нялхсын эндэгдэл Налайх дүүрэгт Улаанбаатар хотын дунджаас 4.5-аар өндөр байна.

In 2018, 555 cases of infants were registered in Ulaanbaatar and it increased by 66 cases or 13.5% compared to the previous year, cases per 1,000 live births escalated to 13.6 which indicated increase by 0.9. 21.6% of infant mortality occurred in the subordinated hospitals of UB Health Department, 78.4% of them happened in the affiliated hospitals of Ministry of Health. Infant mortality rate was higher in Nalaikh district than the UB city average by 4.5 promile.



Нялхсын эндэгдлийн 47.0 хувь нь нярайн эрт үед, 20.4 хувь нь нярайн хожуу үед, 32.6 хувь нь 29-365 хүртэлх хоногтойдоо эндсэн байна.

НЭМГ-ын харьяа эмнэлгүүдэд бүртгэгдсэн нялхсын эндэгдлийн 58.3 хувь нь эрт үед, 17.5 хувь нь нярайн хожуу үед, 24.2 хувь нь 29-365 хүртэлх хоногтойдоо эндсэн байна.

Улсын хэмжээнд тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн 1310 тохиолдол бүртгэгдсэнээс Улаанбаатар хотод 657 тохиолдол буюу 50.2 хувь нь бүртгэгдсэн байна. Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийг тогтмол хаягаар авч үзэхэд УБ хотын харьяаллын тав хүртэлх насны хүүхдийн нас баралт 438 болж өмнөх оноос 39 тохиолдлоор нэмэгдсэн байна.

Улаанбаатар хотод бүртгэгдсэн нэг хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн 555 тохиолдлын 361 нь буюу 65.0 хувь нь УБ хотын харьяаллын хүүхдүүд эндсэн байна.

УБ хотод эндсэн нэг хүртэлх насны хүүхдийн эндэгдэл дотор хөдөө орон нутгаас 194 хүүхэд эндсэн байна.

47.0% of total infant mortality registered at the early period of infancy, 20.4% during the late period and 32.6% were deceased within 29-365 days old.

58.3% of total infant mortality registered at the early period of infancy, 17.5% during the late period and 24.2% were deceased within 29-365 days old in the subordinated hospitals of UB Health Department.

In Mongolia, there are 1310 cases of under five years old child mortality registered and 657 or 50.2% of them was registered in UB. When the permanent address was used to determine under five years old child mortality in Ulaanbaatar it reached 438 and increased by 39 cases from the previous year.


361 or 65.0% of total 555 cases of infant mortality were citizens of UB.

Of total infant mortality registered in UB, 194 cases were from the countryside.



Нялхас болон тав хүртэлх хүүхдийн эндэгдлийн шалтгаан, 2018 он
Causes of Infant and Under- five children mortality, 2018

Шалтгаан /Main Causes	1 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл /Infant mortality		5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл /Under five mortality	
	Бодит тоо /Number	Хувь /Percentage	Бодит тоо /Number	Хувь /Percentage
Перинаталь үед үүссэн зарим эмгэг /Conditions originating in the perinatal period	337	60.7	337	51.3
Төрөлхийн гажиг, гаж хөгжил /Congenital abnormalities and chromosomal disorders	104	18.7	120	18.3
Амьсгалын замын тогтолцооны өвчин /Diseases of respiratory system	37	6.7	51	7.8
Гадны шалтгаант өвчлөл ба нас баралт /External causes of morbidity and mortality	18	3.2	51	7.8
Мэдрэлийн тогтолцооны өвчин /Diseases of the nervous system and sense organs	8	1.4	20	3.0
Халдварт өвчин /Certain infectious and parasitic diseases	16	2.9	21	3.2
Хоол боловсруулах тогтолцооны өвчин /Diseases of the digestive system	13	2.3	18	2.7
Хавдар /Neoplasms	4	0.7	13	2.0
Бусад/ Other	18	3.2	26	4.0
Нийт/ Total	555	100	657	100



Нэг хүртэлх насны хүүхдийн эндэгдэл сүүлийн жилүүдэд буурсан хэдий ч перинаталь үед үүссэн эмгэг өвчлөлийн хамааралтай нас баралт тэргүүлэх шалтгаан болсоор байна.

Нярайн эрт үеийн перинаталь үед үүссэн эмгэгийн нас баралтад нярайн амьсгалын дутагдал 31.5 хувийг, төрөх үеийн хүнд бүтэлт 7.4 хувийг, нярайн ишемийн шалтгаант энцефалопати 38.0 хувийг эзэлж байна.

Амьсгалын тогтолцооны өвчлөлөөс шалтгаалсан эндэгдэл дотор уушгины хатгаагаар 90.0 хувь, төрөлхийн гажгаас 36.5 хувийг зүрх судасны гажиг, 20.8 хувийг хоол боловсруулах эрхтэн тогтолцооны гажиг, 42.7 хувийг бусад эрхтэн тогтолцооны төрөлхийн гажиг тус тус эзэлж байна.

Although infant mortality decreased, disorders that were originated in the perinatal period remained as leading factors of death.

Among disorders developed in early perinatal period, respiratory distress syndrome accounted for 31.5%, severe birth asphyxia 7.4%, hypoxic ischaemic encephalopathy of newborn 38.0%.

Mortality caused by respiratory system that contributed to the infant mortality were pneumonia 90.0%, among congenital pathologies cardiovascular disorder comprise of 36.5%, congenital disorder of digestive system 20.8% and other congenital disorders 42.7%.



Тав хүртэлх насны хүүхдийн бэртэл, хордлого, осол гэмтлийн гадны шалтгаант нас баралтын 51 тохиолдол бүртгэгдсэн ба 42 буюу 82.4 хувь нь УБ хотын харьяаллын хүүхэд эндсэн нь өмнөх оноос 4 тохиолдлоор нэмэгдсэн байна.

Нэг хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн 18 буюу 3.2 хувь нь, 1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн 33 буюу 32.3 хувийг осол гэмтлийн шалтгаант эндэгдэл эзэлж байна.

Осол гэмтлийн шалтгаант эндэгдлийг хэлбэрээр авч үзвэл 78.4 хувийг бусад осол эзэлж байна. Бусад ослоор эндсэн эндэгдлийн дотор түлэгдэлтээр 25.0 хувь, амьсгал боогдсоноос 27.5 хувь, унаж бэртсэнээс 12.5 хувь, хорт бодист өртөх 17.5 хувь, живэх 10.0 хувь, осгох 2.5 хувь, тогонд цохиулах 2.5 хувийг тус тус эзэлж байна.

Бусад ослоор эндсэн хүүхдүүдийн 25.0 хувь нь түлэгдэлтээр эндсэн нь өмнөх оноос 7.3- аар буурсан байна.

Улсын хэмжээнд 1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн 273 тохиолдол бүртгэгдсэнээс Улаанбаатар хотод 102 тохиолдол буюу 37.4 хувь нь, 171 тохиолдол буюу 62.6 хувь нь хөдөө орон нутгаас бүртгэгдсэн байна.

Улаанбаатар хотод 1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн 102 тохиолдол бүртгэгдсэний 75.5 хувь буюу 77 тохиолдол нь Улаанбаатар хотын харьяат, 24.5 хувь буюу 25 тохиолдол нь хөдөө орон нутгаас ирж энджээ.

Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн шалтгааныг өмнөх онтой харьцуулахад амьсгалын замын өвчлөл 0.8 хувиар, гадны шалтгаант нас баралт 0.1 хувиар буурсан бол төрөх тойрны перинаталь үеийн эмгэг 0.7 хувиар, төрөлхийн гажиг 1.3 хувиар тус тус нэмэгдсэн байна.

51 cases registered Under-five mortality in Ulaanbaatar was caused by injury, food poisoning, accidents. 42 or 82.4% of them were citizens of UB and this number increased by 4 cases compared to the previous year.

18 cases or 3.2% and 33 or 32.3% accounted for infant and 1-5 years old children mortality respectively.

In the form of injury-related injuries, 78.4 percent are other accidents. Percentage of other accidents includes falling from the height (12.5%), shortness of breathing (27.5%), burns (25.0%), drowning (10.0%), exposure to poisonous substance (17.5%), chilblains (2.5%), exposure to electric current (2.5%).


Of children's mortality of other injuries 25.0 percent died of burns showing a drop by 7.3 from the previous year.

Nationwide, 273 cases of mortality of children aged 1-5 were registered, in UB 37.4% or 102 of them occurred while in the countryside 171 or 62.6% was registered.


102 cases of 1-5 years old children mortality were registered in UB and 75.5% or 77 were citizens of UB and 24.5% or 25 were from the countryside.

The cause of the mortality of children aged Under-five, compared to 2017, diseases of respiratory system 0.8%, external factors decreased by 0.1%, conditions originating in the perinatal period increased by 0.7%, congenital abnormalities or genetic disorders 1.3%.

Нялхсын эндэгдлийн тэргүүлэх шалтгаан, хувиар, 2016-2018 он
Causes of infant mortality, by percentage, 2016-2018



Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн тэргүүлэх шалтгаан, хувиар, 2016-2018 он
Causes of under five mortality, by percentage, 2016-2018



1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн 102 тохиолдол бүртгэгдсэн нь амьд төрсөн 1000 хүүхдэд харьцуулахад 2.5 болж өмнөх оноос 0.2 промилиор буурсан байна.


Улаанбаатар хотод 5-19 насны хүүхдийн эндэгдлийн 157 тохиолдол бүртгэгдсэн нь өмнөх оноос 15-аар нэмэгдсэн ба үүнээс Улаанбаатар хотын харьяаллын 115 тохиолдол буюу 73.2 хувийг эзэлж байна.

102 cases of 1-5 years old children mortality were registered and if compared to per 1000 children it reached 2.5 and decreased by 0.2 promile compared to the previous year.

From 157 cases of the mortality of children aged 5-19, 73.2% or 115 were residents of UB and it increased by 15 cases compared to the previous year.



5-19 насны хүүхдийн эндэгдэл бодит тоо, дүүргээр, 2016-2018 он
Mortality rate of children aged 5-19 years old, by district, 2016-2018



10-19 насны өсвөр насны хүүхдийн нас баралтын 107 тохиолдол бүртгэгдсэн ба 72 буюу 67.3 хувийг УБ хотын харьяаллын хүүхэд эзэлж байна. УБ хотын харьяалалтай өсвөр насны хүүхдийн эндэгдлийн 72 тохиолдлоос нь 35 буюу 48.6 хувь нь гаднын шалтгаант нас баралт эзэлж байгаа нь өмнөх оноос 6 тохиолдол буюу 14.6 хувиар, эндэгдэлд эзлэх хувь 7.6 хувиар тус тус буурсан байна.

Өсвөр насны хүүхдийн эндэгдлийн тэргүүлэх шалтгаанд сүүлийн жилүүдэд бэртэл хордлого, гадны шалтгаант өвчлөл, эндэгдэл тэргүүлэх байранд орсоор байна.

10-14 насны 10000 хүүхэд тутмын 1.4 нь осол гэмтлээр эндсэн нь өмнөх оноос 0.5-аар буурсан бол 15-19 насны 10000 хүүхэд тутмын 4.5 нь эндсэн нь өмнөх оноос 0.6-аар нэмэгдсэн статистик үзүүлэлт гарч байна.

Өсвөр үеийнхний дотор амиа хорлох, бусад осол, зам тээврийн ослоор дийлэнх нь нас барсан нь тулгамдсан асуудлын нэг хэвээр байсаар байна.

107 cases of the death of teenagers aged 10-19 were registered of which 72 or 67.3% were children of UB. 35 or 48.6% out 72 death cases in UB were caused by the external factor which is a decrease from previous year by 6 case (14.6%), percentage among total mortality 7.6 points.

The leading causes of teenager mortality during the last years are injury, external factors and accidents.

1.4 per 10000 children aged 10-14 deceased due to the accidents decreased by 0.5 compared to the 2017; 4.5 per 10000 children deceased in age 15-19 which by 0.6% compared to the previous year.

Among teenagers, suicide and death from the traffic accidents and other accidents are the serious public health issues.



Өсвөр үеийнхний гадны шалтгаант эндэгдлийн тэргүүлэх шалтгаан, хувиар, 2014-2018 он
Leading causes of teenager mortality that was caused by external factors, 2014-2018

Нас барсан хэлбэр/ Etiology of death	2014		2015		2016		2017		2018	
	Бодит тоо/ Number	Хувь/ Percentage	Бодит тоо/ Number	Хувь/ Percentage	Бодит тоо/ Number	Хувь/ Percentage	Бодит тоо/ Number	Хувь/ Percentage	Бодит тоо/ Number	Хувь/ Percentage
Амиа хорлосон/ Suicide	17	26.2	16	27.1	19	32.8	11	26.8	11	31.4
Бусдад хорлогдсон/ Killed by others	2	3.1	1	1.7	1	1.7	1	2.4	2	5.7
Зам тээврийн осол/ Traffic accidents	11	16.9	10	16.9	4	6.9	6	14.6	5	14.3
Бусад осол/ Other accidents	33	50.8	28	47.5	32	55.2	23	56.1	16	45.7
Тодорхой бус/ Injuries of uncertain etiology	1	1.5	2	3.4	2	3.4	0	0	1	2.9
Үйлдвэрийн осол/ Industrial accidents	1	1.5	2	3.4	0	0	0	0	0	0.0
Нийт /Total	65/100%		59/100%		58/100%		41/100%		35/100%	

10-19 насны хүүхдийн эндэгдлийн тэргүүлэх 5 шалтгаанд бэртэл хордлого, гадны шалтгаант нас баралт 48.6 хувийг, хавдар 18.1 хувь, мэдрэлийн тогтолцооны өвчин 12.5 хувь, амьсгалын тогтолцооны өвчин 6.9 хувь, шээс бэлгийн тогтолцооны өвчин 2.8 хувь тус тус эзэлж байна.

To the leading causes of the mortality of teenagers aged 10-19, injury and poisoning, death due to external causes accounted for 48.6%, cancer 18.1%, disorders of nervous system 12.5%, diseases of respiratory system 6.9% and diseases of genito urinary system 2.8%.



БҮЛЭГ III. ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ

Монгол улсын эрүүл мэндийн байгууллагын тогтолцоо нь нийгмийн эрүүл мэнд, эмнэлгийн тусламж үйлчилгээ, эм хангамж, анагаах ухааны боловсрол, эрдэм шинжилгээ, сургалтын үйл ажиллагаа хариуцсан төрийн, хувийн хэвшлийн, холимог өмчийн эрүүл мэндийн байгууллагаас бүрддэг.

Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ нь дараах 2 төрөлтэй байна. Үүнд:

- нийгмийн эрүүл мэндийн
- эмнэлгийн тусламж үйлчилгээ

Эмнэлгийн тусламж, үйлчилгээ нь:

- Өрхийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ,
- Эмнэлгийн мэргэшсэн тусламж, үйлчилгээ,
- Эх барихын тусламж, үйлчилгээ,
- Хойшлуулшгүй үзүүлэх эмнэлгийн яаралтай тусламж,
- Түргэн тусламжийн үйлчилгээ,
- Сувилахуйн дагнасан тусламж, үйлчилгээ
- Сэргээн засах тусламж, үйлчилгээ гэсэн төрөлтэй байна.¹

2018 оны байдлаар Монгол Улсад 4343 эрүүл мэндийн байгууллага үйл ажиллагаа явуулж байгаагаас Улаанбаатар хотод Төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төв 13, Дүүргийн нэгдсэн эмнэлэг, эрүүл мэндийн төв 13, Амаржих газар 3, Тосгоны эрүүл мэндийн төв 4, Өрхийн ЭМТ 133, Бусад эмнэлэг 14, Хувийн ортой эмнэлэг 137, Сувилал 58, Клиникийн 935 эмнэлэг тус тус эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлж байна.

CHAPTER III. MEDICAL CARE SERVICES

The health care system in Mongolia comprises from the state-owned, private and mixed health organizations, which render public health, medical, pharmaceutical, medical education, research and training services to the population.

The health care and services includes the following two types:

- Public health care
- Medical health care

The health care and services:

- Family Health care and service,
- Hospital specialized care and service,
- Obstetrics and gynecology care and service,
- Emergency care,
- Ambulance care,
- Nursing care services
- Rehabilitation care and service.¹

As of 2018, there are 4343 health organizations in Mongolia providing health care services to the population. There were 13 central hospitals and specialized professional center, 13 district general hospitals and health centers, 3 maternity hospitals, 4 village health centers, 133 family health care centers, 14 other hospitals, 137 private hospitals, 58 sanatorium and 935 private clinics are providing health care services.

¹ Эрүүл мэндийн тухай хууль, 2011

¹ Health laws, 2011



Эрүүл мэндийн байгууллага, анхан болон лавлагаа шатлалаар, 2018 он
Number of health facilities, 2018

Эрүүл мэндийн байгууллага /Health care organization	Улс /Mongolia	Нийслэл /UB city
Өрхийн эрүүл мэндийн төв /Family health centres	219	133
Сум, тосгоны эрүүл мэндийн төв /Soum/village health centres	273/19	4
Сум дундын эмнэлэг /Inter-soum hospitals	39	0
Дүүргийн нэгдсэн эмнэлэг, эрүүл мэндийн төв /District health centers and general hospital	13	13
Хөдөөгийн нэгдсэн эмнэлэг /Rural general hospital	6	0
Аймгийн нэгдсэн эмнэлэг /Aimag general hospital	28	0
Бүсийн оношилгоо эмчилгээний төв /Regional diagnostic and treatment centres	5	0
Төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төв /Central and specialised hospitals	13	13
Амаржих газар /Maternity hospital	3	3
Ортой хувийн эмнэлэг /Private hospitals	243	137
Клиник хувийн эмнэлэг /Private clinics	1340	935
Сувилал /Sanatoriums	107	58
Эм ханган нийлүүлэх байгууллага /Drug supply companies	437	369
Эмийн үйлдвэр /Drug manufacturer	47	47
Хувийн эмийн сан /Private pharmacies	1460	873
Бусад /ЭМЯ, ЭМХТ, НЭМХ, АУХ, Анагаах ухааны сургууль, коллеж, хилийн цэрэг, Батлан хамгаалах, төмөр замын эмнэлэг гэх мэт/ /Other	50	14
Бүгд /Total	4343	2617

3.1. АМБУЛАТОРИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ

2018 онд НЭМГ-ын харьяа байгууллагад дунджаар 8.299.1 сая үзлэг хийгдсэн нь өмнөх оноос 210834 буюу 2.5 хувиар буурсан ба нийт үзлэгийн 46.6 хувийг өрх, 0.9 хувийг тосгоны эмчийн үзлэг, 29.0 хувийг дүүргийн эрүүл мэндийн төв, 8.3 хувийг бусад эмнэлэг, 15.2 хувийг хувийн эмнэлгийн үзлэг тус тус эзэлж байна.

Улсын хэмжээнд нэг эмчид ногдох хүний тоо 282.8 байгаа бол нийслэлийн хэмжээнд энэ үзүүлэлт 208 байна. Нэг өрхийн эмчид ногдож байгаа үзлэгийн тоо улсын хэмжээнд 5634.5 байгаа бол нийслэлд 5926.8 байна.


3.1. OUTPATIENT MEDICAL CARE AND SERVICE

In 2018, there has been 8,299,1 million examination conducted in the affiliated organizations of UBHD which is 210,834 or 2.5% lower compared to previous year. Out of all examination 46.6% were done by family health physicians, 0.9% conducted by village health physicians, 29.0% were done at district health center, 8.3% were at other hospitals and 15.2% were conducted at private hospitals.


The ratio of patients to physician nationwide is 282.8 whereas in the Ulaanbaatar it is 208. Number of examinations per FHC doctor in the country and Ulaanbaatar were 5634.5 and 5926.8 respectively.



Нийт үзлэг, эмнэлгийн тусламж, үйлчилгээний төрөл, хувиар, 2018 он Type of outpatient visits, 2018



Нийт үзлэгийн бүтэц, хувиар, 2018 он /Health services, by organization, 2018



Амбулаторийн тусламж, үйлчилгээний зарим үзүүлэлтүүд, 2009-2018 он Some indicators health care services, 2009-2018

Үзүүлэлт /Indicator	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018
10000 хүн амд ногдох нийт ажиллагсад /Total number of health sector's employee per 10000 population	173.5	171.2	163.1	172.0	172.2	174.9	181.2	178.0	195.3	199.5
10000 хүн амд ногдох их эмч /Physician per 10000 population	39.6	40.3	38.8	41.1	40.9	42.4	42.3	42.2	45.9	48.2
Жилд нэг иргэний үзүүлсэн дундаж тоо /Average number of outpatient visits per person per year	7.3	7.0	7.5	6.5	6.3	6.4	6.4	6.4	7.4	7.3
Урьдчилан сэргийлэх үзлэгийн хувь /Presentage of check-ups	29.2	31.7	27.2	29.6	28.2	29.9	29.4	30.7	30.1	28.6
Хүн амын эрүүл мэндийн индекс/Population Health Index	45.0	46.2	47.2	48.5	45.4	46.7	49.7	44.9	50.7	51.5
Нэг их эмчид ногдох хүний тоо /Number of population per physician	252.3	247.9	257.9	243.1	244.8	236.1	236.5	236.9	217.6	282.8



Мэс заслын хагалгаа, Улаанбаатар хот, 2018 он
Number of surgeries performed in Ulaanbaatar hospitals, 2018

Байгууллага /Organization	Мэс засал хийлгэсэн хүний тоо / Number of people operated		Үүнээс /Out		Мэс заслын дараах хүндрэл /Postoperative complications		Нас барсан хүний тоо /Number of death	
	Бүгд /Total	0-15 насны /0-15	Дурангийн мэс засал/ Endoscopic surgery	Давтан хагалгаа Repeat surgery	Бүгд /Total	0-15 насны /0-15	Бүгд /Total	0-15 насны /0-15
НЭМГ-ын харьяа улсын эмнэлэг /State hospitals	91857	23280	434	8	7	0	1	0
НЭМГ-т мэдээ ирүүлдэг бусад эмнэлэгүүд/ Other hospitals	7636	8	847	16	2	0	15	0
НЭМГ-ын харьяа хувийн эмнэлэг/ Private hospitals	34348	5972	404	32	274	3	0	0
ЭХЭМҮТ /National Centre for Maternal and Child	16632	9225	251	61	61	35	0	0
УНТЭ / I State Central Hospital	11967	37	2001	23	23	0	13	0
УХТЭ /II State Central Hospital	2723	0	1201	7	6	0	13	0
УГТЭ /III State Central Hospital	6729	148	905	17	27	2	26	3
ГССҮТ /National Centre of Traumatology and Orthopaedics	10998	1981	0	5	5	0	146	14
ХСҮТ /National of Cancer Centre	2646	7	179	2	82	0	23	0
ХӨСҮТ /National center for communicable diseases	618	56	0	6	0	0	0	0
ЭМЯ-ны харьяа хувийн эмнэлэг /Private hospitals under МОН	10685	456	2137	21	2	0	0	0
Бүгд /Total	196839	41170	8359	198	489	40	237	17



Түргэн тусламжийн үйлчилгээ

Нийслэлийн хүн амд үзүүлэх түргэн тусламжийн үйлчилгээг нийслэлийн Түргэн тусламжийн төв, түүний салбарууд, алслагдсан дүүргийн эрүүл мэндийн төв болон тосгодын эрүүл мэндийн төвүүд үйлчилгээг үзүүлж байна.

Түргэн тусламжийн үйлчилгээний эрх зүйн орчинг сайжруулах зорилгоор 2018 онд түргэн тусламжийн төвийн бүтэц, үйл ажиллагааны стандартыг анх удаа боловсруулан Стандарт хэмжил зүйн газрын Стандартчилалын Үндэсний зөвлөлийн тогтоолоор “Түргэн тусламжийн төвийн бүтэц, үйл ажиллагаа” MNS 6717:2018 батлуулан мөрдөж эхлээд байна.

Нийслэлийн хүн амд үзүүлэх түргэн тусламжийн үйлчилгээний төвлөрлийг сааруулах, шуурхай байдлыг хангах зорилгоор Чингэлтэй салбарыг байгуулахаар төлөвлөж, үйл ажиллагаа эхлээд байна.

2018 оны байдлаар 363862 дуудлага хүлээн авч үйлчилсэн ба өмнөх оноос 14091 буюу 4.0 хувиар нэмэгдсэн байна. Нийт дуудлагын дотор хүүхдийн түргэн тусламжийн дуудлага 14.1 хувийг эзэлж байна.

Emergency care and service


UB city Emergency Medical Center and its branches in distant districts of the Capital provide ambulance and other emergency medical services to the population.

A national standard (MNS 6717:2018) on “Structure and Standard Operating Procedures of Emergency Medical Center” was approved and enacted by the National Standardization Authority in 2018 for the first time. It serves as substantial step towards improving legal framework of emergency medical service in the country.

In order to improve emergency medical services and decentralize the service ensuring efficiency and access, 4th branch of Emergency medical center is to be established in Chingeltei district.

As of 2018, 363,862 ambulance calls were received which increased by 4.0% (by 14091 calls) compared to the previous year. 14.1% of the total calls were due to pediatric emergency.

Насанд хүрэгчдийн дуудлагын төрөл, хувиар, 2015-2018 он
Cases of emergency calls, by percentage, 2015-2018



2018 онд насанд хүрэгчдийн нийт дуудлагын 70.5 хувийг гэнэтийн өвчлөлийн, 7.0 хувийг төрөхийн, 17.4 хувийг осол гэмтлийн дуудлага эзэлж байна. Осол гэмтлийн дуудлага өмнөх оноос 2.2 хувиар буурчээ.

In 2018, out of total ambulance call for adults 70.5% of the emergency calls are due to acute medical cases, 7.0% are due to obstetric emergencies, 17.4% are due to accidents and injury. Emergency calls due to accidents and injuries decreased by 2.2 percent from the previous year level.



Нийт дуудлагын 9.7 хувь нь гудамжны, 6.2 хувь нь зам тээврийн осол, 0.5 хувь нь амиа хорлосон, 3.2 хувь нь бусдад хорлогдсон, 1.3 хувь нь үйлдвэрийн осол, 0.2 хувь нь спортын, 17.5 хувь нь архины хордлогын, 61.5 хувийг бусад осол тус тус эзэлж байна.

2018 онд хүүхдийн осол гэмтлийн дуудлага 412 бүртгэгдсэний 38.8 хувийг ахуйн осол гэмтэл, 17.7 хувийг түлэгдэлт, 3.6 хувийг угаарын хийн хордлого, 3.9 хувийг эмийн бодисын хордлого, 3.4 хувийг химийн бодисын хордлого, 2.7 хувийг хоолны хордлого, 24.0 хувийг бусад осол тус тус эзэлж байна.

9.7% of call were due to street call, 6.2% were due to road accidents, 0.5% were due to suicide, 3.2% were due to poisoning from external source, 1.3% due to factory related accidents, 0.2% due to sport, 17.5% due to alcohol poisoning and 61.5% were due to other types of accidents and injury.

In 2018, 412 ambulance calls for child injury and accidents. 38.8% of this call registered for accidents within home, 17.7% were due to burn, 3.6% due to carbon monoxide toxicity, 3.9% due to intoxication from medicine, 3.4% from intoxicity due to chemical substance, 2.7% food poisoning, 24.0% due to other types of accidents and injury.



3.2. ХЭВТҮҮЛЭН ЭМЧЛЭХ ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ

Улсын хэмжээнд 2018 оны байдлаар эмнэлэгт 902439 үйлчлүүлэгч хэвтэн эмчлүүлж 6438504 ор хоног ашигласан бөгөөд дундаж ор хоног 7.1 байна. Улаанбаатар хотын ор бүхий эмнэлэгт нийт 452707.5 хүн хэвтэн эмчлэгдэн 3244231 ор хоног ашигласан бөгөөд ор ашиглалтын хувь 88.3, дундаж ор хоног 7.2, орны эргэлт 40.7 байна.

Нийт хэвтэн эмчлүүлэгсдийн өвчлөлд Улаанбаатар хотын харьяаллын иргэдийн өвчлөл 80.0 хувийг эзэлж байна. Нийслэлийн эрүүл мэндийн газрын харьяа болон бусад мэдээ өгдөг ор бүхий эмнэлгүүдэд 294549.5 хүн хэвтэн эмчлэгдэж, 1941797 ор хоног ашигласан бөгөөд ор ашиглалтын хувь 81.7, дундаж ор хоног 6.6, орны эргэлт 40.9 байна.

3.2. INPATIENT SERVICE

In 2018, On national level 902,439 patients were admitted to hospitals, 6,438,504 beds were used and average length of stay was 7.1. In Ulaanbaatar, 452,707.5 patients received inpatient health service and 3,244,231 beds were used. The percentage of bed usage 88.3, average length of stay 7.2, the bed turnover was 40.7.

Citizens in Ulaanbaatar accounted for 80.0% of inpatients. 294,549.5 inpatients received services in subordinated hospitals in UB Health Department or other hospitals /that report to the UB Health department/ and used 1,941,797 beds. The percentage of bed utilization was 81.7 and average length of stay was 6.6, bed turn over was 40.9.



Хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээ, 2018 он /Inpatient service, 2018

N:	Байгууллага /Organization		Орны тоо /Number of hospitals beds	Үүнээс: хүүхдийн орны тоо /In: number children's beds	Эмчлэгдсэн өвчтөн Number of inpatient hospitals	Фонд ашиглалтын хувь/Percentage of bed fund	Эмнэлгийн нас баралт /Number of inpatients mortality		Дундаж ор хоног /Average length of stay	Орны эргэлт /Number of patient per bed year
							Бодит тоо /Number	Хувь /Percent		
1	Эрүүл мэндийн төв /District health centers	Хан-Уул /Khan Uul	90	0	4219	97.7	12	0.3	6.9	46.9
2		Сонгинохайрхан /Songinokhairhan	208	0	10367	112.5	60	0.6	7.4	49.8
3		Чингэлтэй /Chingeltei	252	80	10895.5	94.8	59	0.5	7.2	43.2
4		Баянгол /Bayangol	400	197	22444.5	113.6	40	0.2	6.3	59.1
5		Багануур /Baganuur	214	51	8512	82.0	25	0.3	6.9	39.4
6		Налайх/ Nalaikh	211	40	7448.5	73.9	19	0.3	7.0	34.7
7		Багахангай /Bagahangai	15	4	403	44.6	0	0.0	7.3	20.2
8	Нэгдсэн эмнэлэг /District general hospitals	Сүхбаатар /Sukhbaatar	325	120	16907.5	108.5	109	0.6	6.5	55.4
9		Сонгинохайрхан /Songinokhairhan	165	155	11419	109.1	3	0.03	5.2	69.2
10		Хан-Уул /Khan Uul	205	80	10346.5	99.4	15	0.1	6.5	50.5
11		Баянзүрх /Bayanzurkh	458	230	22535	99.5	105	0.5	6.7	49.2
12	Амаржих газар /Maternity hospitals	Өргөө /Urguu	363	23	27581.5	94.0	47	0.2	4.1	76.0
13		Хүрээ /Khuree	85	10	6895	76.4	6	0.1	4.4	57.5
14		Амгалан /Amgalan	200	10	15347.5	90.9	28	0.2	3.9	76.8
15	Бусад эмнэлгүүд / Other	Энэрэл /Enerel	74	0	3340	89.1	26	0.8	7.4	39.8
16		Наркологи /Narcology	45	0	2063	112.6	1	0.05	8.1	45.8
17		СЗКЭ /Rehabilitation clinic	175	0	5558.5	104.7	0	0.0	9.2	37.6
18	Тосгоны эрүүл мэндийн төв / Village health center	Гачуурт /Gachuurt	17	5	771	93.9	0	0.0	6.8	45.4
19		Жаргалант /Jargalant	15	4	673	85.3	0	0.0	6.3	44.9
20		Туул /Tuul	15	5	363	46.9	0	0.0	6.4	24.2
21		Хонхор /Khonhor	15	4	342.5	43.5	0	0.0	6.3	22.8
22	Хувийн эмнэлэг /Private hospitals		2253	70	60663	57.3	9	0.01	7.0	26.9
Бүгд /Total			5789	1088	249137.5	81.3	564	0.2	6.3	43.0



Нийслэлийн хэмжээнд эмнэлгийн нас баралтын 2700 тохиолдол бүртгэгдсэний 20.6 хувь нь НЭМГ-ын харьяа ор бүхий эмнэлэгт, 2.6 хувь нь НЭМГ-т мэдээ өгдөг бусад эмнэлэгт, 0.3 хувь нь хувийн эмнэлэгт, 76.5 хувь нь ЭМЯ-ны харьяа эмнэлгүүдэд бүртгэгджээ.

Хоног болоогүй 506 нас баралтын 67.6 хувь нь ЭМЯ-ны харьяа ор бүхий эмнэлгүүдэд, 28.1 хувь нь НЭМГ-ын харьяа ор бүхий эмнэлэгт, 4.3 хувь нь НЭМГ-т мэдээ өгдөг бусад эмнэлэг, хувийн эмнэлгүүдэд бүртгэгдсэн байна.


НЭМГ-ын харьяа болон НЭМГ-т мэдээ өгдөг бусад эмнэлгүүдэд нийт 564 эмнэлгийн нас баралт бүртгэгдсэний 142 буюу 25.2 хувь нь хоног болоогүй нас баралт, үүнээс 83 буюу 58.5 хувь нь 8-24 цагийн дотор нас барсан байна.

In 2018, across the capital city, 2,700 cases of inpatients mortality were registered and 20.6 of them at the subordinated hospitals of UB Health Department, 2.6% at other hospitals /that report to the UB Health department/, 0.3% at private hospitals, 76.5% at subordinated hospitals of Ministry of Health.


67.6% of 506 mortalities occurred within 24 hours of admission in subordinated hospitals of Ministry of Health, 28.1% in the subordinated hospitals of UB Health Department, 4.3% at the hospitals that provide report to UB Health department.

Total 564 hospital deaths were registered at the subordinated hospitals of UB Health Department and 142 or 25.2 % of them deceased within 24 hours of admission, 83 or 58.5% within 8-24 hours.

Хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээний үзүүлэлт, 2009-2018 он
Inpatient service, 2009-2018



Эмнэлгийн орны үзүүлэлт, 2009-2018 он
/Utilization of hospital beds, 2009-2018





Хөнгөвчлөх тусламж үйлчилгээ

Хорт хавдрын тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, үйлчлүүлэгчдийн хүлээгдэл, чирэгдлийг бууруулах зорилгоор бүх дүүргийн нэгдсэн эмнэлэг, ор бүхий эрүүл мэндийн төвүүдэд хөнгөвчлөх эмчилгээний нэгж, тасаг нээгдэн үйл ажиллагаа явуулж эхэлсэн. 2018 оны байдлаар хөнгөвчлөх эмчилгээний 48 оронд нийт 1177 өвчтөнд тусламж үйлчилгээ үзүүлж, 8777 ор хоног ашигласан бөгөөд дундаж ор хоног 7.4 байна.

Хорт хавдрын хими эмчилгээ

2018 онд Баянгол, Багануур, Сонгинохайрхан, Хан-Уул, Налайх дүүргийн эрүүл мэндийн төв, Баянзүрх дүүргийн нэгдсэн эмнэлэгт хорт хавдрын өдрийн хими эмчилгээний нэгж ажиллаж эхэлсэн бөгөөд хорт хавдартай 284 өвчтөнд 6-8 удаагийн эмчилгээ хийсэн байна.

3.3. ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ, ШАТЛАЛААР

Өрх, тосгоны эрүүл мэндийн төвийн тусламж, үйлчилгээ

Өрхийн эрүүл мэндийн төв нь хот, суурин газрын хүн амд төрөөс үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээг гэрээгээр гүйцэтгэх үндсэн чиг үүрэг бүхий сайн дурын үндсэн дээр бүртгүүлсэн хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага юм.

Эрүүл мэндийн тухай хууль, Эмнэлгийн тусламжийн тухай хуульд зааснаар иргэдэд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг чанартай, хүртээмжтэй үзүүлэх зорилгоор өрхийн нэг эрүүл мэндийн төвд ногдох иргэний тоог 8000-аас доошгүй байхаар тогтоосон байна.

Palliative care services

In order to improve the quality and accessibility of cancer care services and to reduce costumer expectation, all hospitals of all district and inpatient health centers launched the palliative care units and started operating. As of 2018, 48 beds for all palliative treatments totaled 1,177 patients, and the total number of hospital bed uses are 8,777, and the average bed uses is 7.4%.

Cancer Chemotherapy

In 2018, a chemotherapy units for cancer patients launched and started operating in Bayangol, Baganuur, Songinokhairkhan, Khan-Uul and Nalaikh health centres and Bayanzurkh hospital. Total of 284 cancer patients received 6-8 chemotherapy sessions on average.

3.3. MEDICAL CARE SERVICES, BY STAGE

Family and village health center care services

Family health centers are private health organizations that provide health services to urban and settled population based on contract made with the Government.

As stipulated and required in the Mongolian Law on Health and the Law on Medical care, to provide a high quality, accessible service to its registered inhabitants, there should be at least 8,000 citizens per one family health center.




Өрхийн ЭМТ-ийн бүтэц үйл ажиллагааны стандарт /MNS 5292:2017/, Эрүүл мэндийн сайдын тушаалаар батлагдсан эрх зүйн 4 баримт бичгийн хэрэгжилтийг ханган, ажиллаж байна.

2018 оны байдлаар Улаанбаатар хотын 133 өрхийн эрүүл мэндийн төв, 9 салбарт 405.6 мян өрхийн 1.575.2 мян хүн ам бүртгэлтэй байна. Өрхийн хүн амын бүтцийг насны ангиллаар авч үзвэл нийт хүн амын дотор 0-18 нас хүртэлх хүүхэд 34.8, хөдөлмөрийн насны буюу 20-49 насны хүмүүс 46.7 хувийг эзэлж байна.

National Standard on Structure and Standard Operating Procedures (MNS 5292: 2017) of FHCs and 4 regulatory documents approved by the Order of the Minister of Health shape the legal framework of primary health care service provided by FHCs.

As of 2018, 1,575.2 thousand population or 405.6 households are registered to the 133 FHCs across UB. 34.8% of total population are 0-18 years of age, 46.7% are people of working age (20-49).

Өрхийн хүн ам, насны ангилал, хувиар, 2018 он
Population of FHC, by age group, by percentage, 2018



Бүртгэлд хамрагдсан өрхийн 53.7 хувь нь эрүүл, 32.5 хувь нь бага өртөмтгий, 13.6 хувь нь өвчлөлд өртөмтгий бүлгийн өрхүүд байна.

Нийслэлийн өрхийн эрүүл мэндийн төвд 652 их эмч, 613 сувилагч болон нийт 1762 ажиллагсад хүн амд эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлсэн байна. Нийт ажиллагсдын 89.4 хувь нь эмэгтэйчүүд байна.

Өрхийн эрүүл мэндийн төвийн түвшинд 3.864.3 үзлэг хийгдэж, нэг иргэн жилд дунджаар 2.7 удаа өрхийн эмнэлэгт хандаж эрүүл мэндийн тусламж үйлчилгээг авсан байна.

Out of total registered households, 53.7% are healthy, 32.5% are at low-risk for disease and 13.6% are at high-risk for disease.

In FHCs across the city, total of 1,762 health care professionals deliver primary care service including 652 physicians, 613 nurses. 89.4% of the total staffs are females.

Within the family health center, in average 3.864.3 examinations has been done. One citizen gets health care and service from the family health center in about 2.7 times a year.



2018 оны байдлаар өрхийн ЭМТ-д хийгдсэн үзлэгт:

- урьдчилан сэргийлэх үзлэг 43.0 хувь,
- идэвхтэй хяналтын үзлэг 9.0 хувь,
- гэрийн идэвхтэй эргэлт 29.2 хувь,
- амбулаторийн үзлэг 18.0 хувь,
- гэрийн дуудлага 0.7 хувийг тус тус эзэлж байна.

Энэ нь өмнөх оны мөн үеэс амбулаторийн, урьдчилан сэргийлэх, идэвхтэй хяналтын үзлэг тус тус 0.3 хувиар нэмэгдэж, гэрийн идэвхтэй эргэлтийн үзлэг 0.7, гэрийн дуудлагын үзлэг 0.1 хувиар буурсан байна.

“Өрхийн эрүүл мэндийн төвийн бүтэц, үйл ажиллагааны стандарт”-д гэрийн идэвхтэй эргэлтийн хувь 30-аас доошгүй байна гэж заасан байдаг.

As of 2018, type of services conducted at the Family health center as follows:

- preventative examination 43.0%,
- active follow-up examination 9.0%,
- active home visit 29.2%,
- ambulatory examination 18.0%,
- home call 0.7%.

In comparison to the previous year, ambulatory examinations and active home visits increased by 0.3 each. Active home visits and visits due to home calls decreased by 0.7% and 0.1% respectively.

It is stated in the “Standart for structure and service of family health center” that the percentage of active home visit should be not less than 30%.

Өрхийн эрүүл мэндийн төвийн үзлэгийн хэлбэр, 2009-2018 он
Type of outpatient services Family health center, 2009-2018

Үзүүлэлт /Indicator	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018
Урьдчилан сэргийлэх үзлэгийн хувь /Percentage of preventive health check-ups	40.3	40.9	42.6	45.2	42.6	42.2	42.9	43.7	42.7	43.0
Гэрийн идэвхтэй эргэлтийн үзлэгийн хувь /Percentage of active home visit	31.2	30.4	30.8	28.9	28.5	28.4	28.3	29.0	29.9	29.2
Идэвхтэй хяналтаас эдгэрэлтийн хувь /Percentage of recovery from active control	39.5	42.1	41.7	36.2	39.5	37.2	29.8	32.1	33.2	26.5



Өрх, тосгоны ЭМТ-ийн тусламж үйлчилгээний зарим үзүүлэлт, 2018 он
Some indicators of FHCs health care services, 2018

Үзүүлэлт /Indicator	Өрхийн ЭМТ/ FHC	Тосгоны ЭМТ/ Village health centers	Дүн/Total
Эмнэлгийн тоо /Number of health centers	133	4	137
Их эмчийн тоо /Number of doctors	652	30	682
Сувилагчийн тоо /Number of nurses	613	28	641
Орны тоо /Number of hospital beds	-	82	82
Хэвтэн эмчлүүлэгчийн тоо /Number of inpatients	-	2552.5	2552.5
Дундаж ор хоног /Average length of stay	-	6.6	6.6
Амбулаториор үйлчлүүлэгчдийн тоо /Number of outpatients	3864321	82410	3946.7
Амбулаторийн нийт үзлэгт урьдчилан сэргийлэх үзлэгийн эзлэх хувь /Percentage of check-ups	43.0	35.9	42.8
Нэг иргэний жилд үзүүлсэн удаа /Number of visits per person per year	2.7	2.4	2.5
Өрхийн нэг эмчид ногдох үзлэгийн тоо /Number of outpatient visits per physician	5926.8	2747	5786.9
Жирэмсний эрт хяналтын хувь /Percentage of early antenatal care	88.5	75.2	88.4

Тосгоны эрүүл мэндийн төвд 30 их эмч, 28 сувилагч, 4 бусад бага эмч, 2 эх баригч, 2 багийн бага эмч, 1 эм зүйч, 3 лаборант, нийт 124 ажиллагсад хүн амд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлж байна. Нийт ажиллагсдын 79.8 хувь нь эмэгтэйчүүд байна. Тосгоны эрүүл мэндийн төвд 10748 өрхийн 34870 хүн ам бүртгэлтэй байна. Жилдээ 82.4 мянган үзлэг хийгдэж, нэг иргэн жилд дунджаар 2.4 удаа хандаж эрүүл мэндийн тусламж үйлчилгээг авсан байна.

Өрх, тосгоны эрүүл мэндийн төвд 0-5 хүртэлх насны хүүхдийн идэвхтэй хяналт 2016 онд 90.0, 2017 онд 90.8 хувь байсан бол 2018 онд 62.7 хувь байна.

In village health centers, there were 30 physicians, 28 nurses, 2 mid level physicians, 2 midwives, 2 bag's mid-level physicians, 1 pharmacist, 3 laboratory technicians and totally 124 staffs provide public and primary health care to their affiliated population. 79.8% of all staffs are females. There are 34,870 people of 10,748 households are registered in the village health center. Annually, average of 82.4 examinations are being conducted at this location where one citizen gets health care and service in about 2.4 times per year.

In 2016, active follow-up of children below 5 years old was 90.0% and 90.8% in 2017 and dropped to 62.7% in 2018.




Эрүүл мэндийн сайдын 2017 оны “Өрхийн эрүүл мэндийн төвийн гүйцэтгэлийн гэрээний заавар батлах тухай” А/05 дугаар тушаалд 0-5 хүртэлх насны хүүхдийн гэрийн эргэлт, хяналтыг:

- 2 хүртэлх сартай хүүхдийг 6-аас доошгүй удаа гэрээр 100 хувь эргэх,
- 2 сараас 1 нас хүртэлх хүүхдийг сар бүр үзэж, 90 ээс доошгүй хувийг,
- 1-2 нас хүртэлх хүүхдийг улирал тутам үзэж, 80-аас доошгүй хувийг,
- 2-5 нас хүртэлх хүүхдийг хагас жил тутамд үзэж, 80-аас доошгүй хувийг хянаж байхаар заасан.

In the decree number A/05 “Approval of contract guidelines for Family health center performance” issued by the Minister of Health, the frequency of home and follow-up visit for children below 5 stated as:

- for children below 2 months old, home visit shall be not less than 6 times, follow-up with 100%
- for children from 2 months to 1 year old, home visit shall be once in every month, follow-up with not less than 90%
- for children 1-2 year sold, home visit shall be quarterly, follow-up with not less than 80%,
- for children 2-5 years old, home visit shall be once in every six months, follow-up with not less than 80%

Тав хүртэлх насны хүүхдийн хяналт, хувиар, 2009-2018 он
Active control of children under-five, 2009-2018



Дүүргийн эрүүл мэндийн төв, нэгдсэн эмнэлгийн тусламж, үйлчилгээ

Улаанбаатар хотод 9 эрүүл мэндийн төв, 4 нэгдсэн эмнэлэг, 3 амаржих газар хүн амд амбулатори болон хэвтүүлэн эмчлэх хэлбэрээр эмнэлгийн тусламж, үйлчилгээг үзүүлж байна. Дүүргийн нэгдсэн эмнэлэг, эрүүл мэндийн төвд 869 их эмч, 981 сувилагч ажиллаж байна.

District health centers and general hospitals

Across Ulaanbaatar city, 9 health centers, 4 general hospitals, 3 maternity hospitals are providing both inpatient and outpatient medical service for its inhabitants. There are 869 physicians and 981 nurses working in the district general hospitals and health centers.

**Дүүргийн эрүүл мэндийн төвийн тусламж үйлчилгээ**

Улаанбаатар хотын дүүргийн эрүүл мэндийн төвд 708 их эмч, 703 сувилагч, 285 эмнэлгийн мэргэжлийн болон техникийн боловсролтой бусад ажилтан нийтдээ 2477 эмнэлгийн ажиллагсад ажиллаж байна.

District health centers medical care services

In the district health centers across Ulaanbaatar city, totally 2,477 health professionals are working including 708 physicians, 703 nurses and 285 mid-level medical professionals.

Дүүргийн эрүүл мэндийн төвийн тусламж үйлчилгээний зарим үзүүлэлт, 2018 он
Some health care service indicators of district health centers, 2018

Үзүүлэлт /Indicator	Дүүргийн эрүүл мэндийн төв /District health centers								Нийт дүн /Total
	Баянгол /Bayangol	Баянзүрх /Bayanzurkh	Сонгинохайрхан /Songinokhairhan	Сүхбаатар /Sukhbaatar	Хан-Уул /Khan-Uul	Чингэлтэй /Chingeltei	Багануур /Baganuur	Налайх /Nalaikh	
Эмнэлгийн орны тоо /Number of hospital beds	400	-	208	-	90	252	214	211	1375
Их эмчийн тоо /Number of doctors	117	97	110	61	70	99	76	78	708
Сувилагчийн тоо /Number of nurses	116	48	107	40	70	113	112	105	703
Хэвтэн эмчлүүлэгчийн тоо /Number of inpatient	22444.5	-	10367	-	4219	10895.5	8512	7448.5	63886.5
Дундаж ор хоног /Average length of stay	6.3	-	7.4	-	6.9	7.2	6.9	7.0	6.8
Орны фонд ашиглалтын хувь / Percentage of bed fund	113.6	-	112.5	-	97.7	94.8	82.0	73.9	97.6
Хоног болоогүй нас баралтын хувь /Percentage of deaths occurred within 24 hours of admission	12.5	-	36.7	-	0.0	33.9	16.0	42.1	27.4
Амбулаторийнүзлэг /Number of outpatient	907.2	1197.9	1571.6	632.2	757.1	690.5	237.5	221.4	6215.7
Урьдчилан сэргийлэх үзлэгийн хувь / Presentage of check-ups	40.3	43.0	40.3	34.9	42.1	41.9	41.2	31.5	40.4
Мэс заслын хагалгаа /Number of surgeries	5428	4609	10436	5041	3318	21114	6169	2549	58694



Дүүргийн эрүүл мэндийн төвийн 1375 эмнэлгийн оронд 63886.5 хүн хэвтэн эмчлүүлсэн байна. Дундаж ор хоног 6.8 байна. Хэвтэн эмчлүүлэгчдийн тоо өмнөх оноос 7433.5-аар нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

Хоног болоогүй нас баралтын хувь өмнөх оноос 0.3-аар нэмэгдсэн. Амбулаториор үйлчлүүлсэн хүний тоо өмнөх оноос 197618-аар буурсан байна.

Дүүргийн нэгдсэн эмнэлгийн тусламж үйлчилгээ

Улаанбаатар хотын дүүргийн нэгдсэн эмнэлэгт 161 их эмч, 278 сувилагч, 42 эмнэлгийн мэргэжлийн болон техникийн боловсролтой бусад ажилтан нийтдээ 797 эмнэлгийн ажиллагсад ажиллаж байна.

63886.5 inpatients were admitted to district health centers occupying 1,375 hospital beds. Average length of stay in district hospitals in 2018 was 6.8. Number of inpatient increased by 7433.5 compared to the previous year.

Hospital deaths within 24 hours of admission, increased by 0.3 compared to the previous year. The number of outpatient patients decreased by 197,618 compared to the previous year.

District general hospital medical care services

In the district general hospitals of Ulaanbaatar city, totally 797 staffs are working including 161 physicians, 278 nurses and 42 mid-level medical professionals.

Дүүргийн нэгдсэн эмнэлгийн тусламж үйлчилгээний зарим үзүүлэлт, 2018 он
Some health care service indicators of district general hospitals, 2018

Үзүүлэлт /Indicator	СХНЭ /SKhD	ХҮНЭ /KhUD	СБНЭ /SBD	БЗНЭ /BZD	Нийт /Total
Эмнэлгийн орны тоо /Number of hospital beds	165	205	325	458	1153
Их эмчийн тоо /Number of doctors	20	34	41	66	161
Сувилагчийн тоо /Number of nurses	46	46	75	111	278
Хэвтэн эмчлүүлэгчийн тоо /Number of inpatient	11419	10346.6	16907.5	22535	61208
Дундаж ор хоног /Average length of stay	5.2	6.5	6.5	6.7	6.3
Хоног болоогүй нас баралтын хувь /Percentage of deaths occurred within 24 hours of admission	33.3	0.0	30	31	26.7

Дүүргийн нэгдсэн эмнэлгийн 1153 оронд 61208 хүн хэвтэн эмчлүүлж, дундаж ор хоног 6.3 байгаа нь өмнөх оноос хэвтэн эмчлүүлэгчдийн тоо 5314-өөр нэмэгдэж, дундаж ор хоног 0.2-оор буурсан үзүүлэлттэй байна.

Эмнэлгийн хоног болоогүй нас баралтын хувь өмнөх оноос 7.3-аар буурсан.

The District General Hospital admitted 61,208 patients to their 1,153 bed. An average length of stay was 6.3. Compared to the previous year, number of inpatients increased by 5,314 and the average length of stay in hospitalis decreased by 0.2%.

The hospital deaths within 24 hours of admission was decreased by 7.3%.



Амаржих газрын тусламж үйлчилгээ

Нийслэлд үйл ажиллагаа явуулж буй амаржих газарт нийт 927 ажиллагсад ажиллаж байна.

Нийт 198 эмчийн 55.5 хувийг эх барих, эмэгтэйчүүдийн эмч, 15.1 хувийг сэхээн амьдруулах мэдээгүйжүүлэлтийн их эмч, 19.7 хувийг хүүхэд нярайн эмч эзэлж байна. Сувилагч, тусгай дунд мэргэжилтний 42.9 хувийг эх баригч, бага эмч нар эзэлж байна.

Medical care and service of maternity hospitals

There are 927 staffs are working in all the maternity hospitals across the city.

Out of all 198 physicians, 55.5% are obstetrics and gynecology doctor, 15.1 are intensive care doctors, 19.7 are pediatrician and neonatologist and lastly 42.9% are mid-level health specialists such as midwives and others.

Амаржих газрын тусламж үйлчилгээний үзүүлэлт, 2018 он Medical care services of maternity hospitals, 2018

Үзүүлэлт /Indicator	Өргөө /Urguu	Хүрээ /Khuree	Амгалан /Amgalan	Бүгд /Total
Эмнэлгийн орны тоо /Number of hospital beds	363	120	200	683
Их эмчийн тоо /Number of doctors	105	34	59	198
Сувилагчийн тоо /Number of nurses	139	27	37	203
Эх баригч бага эмч /Number midwives	67	42	53	162
Хэвтэн эмчлүүлэгчийн тоо /Number of inpatients	27604.5	6898.0	15360.5	49824
Дундаж ор хоног /Average length of stay	4.1	4.4	3.9	4.0
Хоног болоогүй нас баралтын хувь /Percentage of hospital deaths within 24 hours of admission	14.9	33.3	14.3	16.0
Төрөлт /Births	11753	4339	8458	24525
Эхийн эндэгдэл /Maternal mortality	1	0	1	2
Нярайн нас баралт /Infant mortality	45	6	27	78
Мэс заслын хагалгаа /Number of surgeries	10164	2077	5593	17834

2018 онд амаржих газарт 24525 эх төрж, 24610 хүүхэд амьд төрсөн байна. Нийт төрөлтийн 0.3 хувийг гэрийн төрөлт эзэлж байна. Амьгүй төрөлтийн түвшин 5.6, төрөлхийн гажигтай төрсөн нярай 0.4 хувь, бага жинтэй нярайн хувь 2.8 байна.

Энэ нь өмнөх оноос амьгүй төрөлтийн түвшин 0.2-оор, бага жинтэй нярай 0.1 хувиар тус тус нэмэгдсэн байна.

In 2018, 24,525 mothers and 24610 children were born in the maternity hospitals. Out of total births, 0.3% were home births. Out of total births, 5.6% are stillbirth, infants with congenital defects are 0.4% and infants with low weight are 2.8%.

Cases of stillbirth increased by 0.2% and number of infants with low birth weight increased by 0.1%.



Нийт 683 ортой амаржих газарт 49824 хүн эмчлэгдэн 202845 ор хоног ашигласан ба ор ашиглалтын хувь 90.0, дундаж ор хоног 4.0, орны эргэлт 73.0 байна. Эмнэлгийн нас баралтын 81 тохиолдол бүртгэгдсэний 2 тохиолдол нь эхийн эндэгдэл, 78 нь нярайн нас баралт, үүнээс 62 нь эрт нярайн эндэгдэл байна. Эмнэлгийн нас баралтын 16.0 хувийг хоног болоогүй нас баралт эзэлж байна.

Нийслэлийн Амгалан амаржих газрын Эмэгтэйчүүдийн эмгэгийг эмчлэх тасагт Radiofrequency myoma ablation (RFA) эмчилгээг умайн хоргүй хавдрыг эмчлэх зорилгоор Монголд анх удаа хэвлийн дурангийн хяналтын дор амжилттай хийж гүйцэтгэлээ.

Цаашид энэхүү мэс заслын бус эмчилгээний аргыг тус амаржих газрын хувьд, эмэгтэйчүүдийн практикт өргөнөөр нэвтрүүлэхийг зорин ажиллаж байна.

Хувийн эмнэлгийн тусламж, үйлчилгээ

Монгол улсад хувийн эмнэлгийн тогтолцоо бүрдсэнээс хойш өнөөг хүртэл хотод 1130, аймагт 560 хувийн хэвшлийн ЭМБ тусламж үйлчилгээ үзүүлж байна.

Улаанбаатар хотод 2018 оны байдлаар нийслэлийн эрүүл мэндийн газрын харьяа ор бүхий 99 эмнэлэг, 55 сувилал, 901 үүдэн эмнэлэг амбулатори, хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээ үзүүлсэн ба 1055 эмнэлэгт 2399 их эмч, 1739 эмнэлгийн тусгай дунд мэргэжилтэн үүнээс 1234 сувилагч, нийт 6030 эмч, эмнэлгийн мэргэжилтэн ажиллаж байна.

2018 онд НЭМГ-ын харьяа хувийн эмнэлгүүд 1260146 амбулаторийн үзлэг хийсэн ба өмнөх оноос 44046-аар нэмэгдсэн байна.

Амбулаторийн үзлэгийн 1.8 хувийг урьдчилан сэргийлэх үзлэг, 97.6 хувийг өвчний учир амбулаторийн үзлэг, 0.4 хувийг идэвхтэй хяналтын үзлэг, 0.1 хувийг гэрийн эргэлт, гэрийн дуудлага эзэлж байна.

In the maternity hospitals hospital beds were accounted 683. Total 49,824 inpatients received care and 202845 beds were utilized. Bed capacity usage was 90.0%, average stay in bed is 4.0 and bed turnover is 73.0. There has been 81 cases of hospital deaths were registered from which 2 of them were maternal death, 78 were infant mortality from which 62 were early infant period. Out of all hospital deaths, 16.0% were deaths within 24 hours of admission.

For the first time in Mongolia, Radio Frequency Ablation (RFA) treatment for myoma was successfully introduced in the Gynecology Department of Amgalan Maternity Hospital of the UB city.

In the future, this non-surgical treatment is aimed to be broadly used in gynecology practice at Maternity Hospitals.

Medical care and service of private health

Since the establishment of private hospital system in Mongolia, we have about 1130 private hospitals in the city and 560 in the aimag level.


In Ulaanbaatar city as of 2018, there are 99 inpatient hospitals, 55 sanatorium, 901 outpatient clinics that operate under supervision of UBHD provided outpatient medical care and service. In these 1055 medical facilities 2399 physicians, 1739 mid-level professionals including 1234 nurses and total of 6030 physicians working to provide medical care and service to the citizens.

In 2018, UBHD affiliated private hospitals conducted total of 1,260,146 outpatient examinations which is 44046 cases higher than the previous year.

Out of all outpatient examination, 1.8% were preventative, 97.6% were due to diseases, 0.4% were active follow-up examinations, and 0.1% were home visits and emergency calls from home.



Амбулаторийн үзлэг кабинетаар, хувиар, 2018 он Type of Outpatient visits, 2018



Хувийн эмнэлгийн тусламж үйлчилгээний зарим үзүүлэлт, 2012-2018 он Some health care services of private hospitals, 2012-2018

Үзүүлэлт /Indicators	2012	2013	2014	2015	2016	2017	2018
Ортой эмнэлгийн тоо /Private hospitals	72	88	88	87	87	95	100
Үүдэн эмнэлгийн тоо /Private clinics	573	798	803	817	829	984	1102
Эмнэлгийн орны тоо /Number of beds	1499	1499	2057	1981	2076	2128	2253
Эмчийн тоо /Number of doctors	1420	1366	1690	1811	1873	2174	2399
Сувилагчийн тоо /Number of nurses	797	727	972	1069	1033	1233	1234
Амбулаторийн үзлэгийн тоо /Outpatient visits	920727	956428	1031575	1094273	1125115	1216100	1260146
Эмнэлэгт хэвтсэн хүний тоо /Number of inpatient	65271	47058	50126	53848	57217	56685	60530
Дундаж ор хоног /Average length of stay	7.5	7.2	7.1	6.8	7.0	7.0	7.0

НЭМГ-ын харьяа хувийн хэвшлийн ор бүхий эмнэлгүүдийн тусламж үйлчилгээ:

Ор бүхий хувийн эмнэлэгт 60662.5 хүн эмчлэгдэн гарсан нь өмнөх оноос хэвтэн эмчлүүлэгчдийн тоо 3967.5 буюу 6.9 хувиар нэмэгдсэн ба дундаж ор хоног 7.0, орны эргэлт 26.9, орны фонд ашиглалтын хувь 57.3 байна.

Medical care and service of UBHD affiliated private inpatient hospitals:

In all private inpatient hospitals, 60,663 people were admitted and received medical care which was 3967.5 or 6.9% higher than the previous year and the average stay was 7.0, bed turnover was 26.9 and usage of bed is 57.3%.



Эмнэлгийн нас баралт 9 бүртгэгдэж үүнээс хоног болоогүй 2, 8-24 цагийн доторх нас баралт 2 байна.

Хувийн эмнэлэгт 209 эх төрж, 209 хүүхэд амьд төрсөн байна.

Ортой эмнэлгүүдийн 88.7% нь дотор, уламжлалт, эмэгтэйчүүд, мэс засал, мэдрэлийн нарийн мэргэжлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна.

Hospital deaths were registered to be 9 and out of this cases, deaths within 24 hours 2, within 8- 24 hours of admission was 2.


In the private hospital, there has been labor of 209 mothers and live births of 209 children.

Out of clinical hospitals, 88.7% are providing service to internal medicine, traditional medicine, gynecology, surgery, and neurological health care and service.

НЭМГ-ын харьяа хувийн ортой эмнэлгийн хэвтэн эмчлүүлэгчдийн хувь, 2018 он
Percentage of inpatient, private hospitals under UB city health department, 2018

Үзүүлэлт /Indicators	Байгууллагын тоо /Number	Хувь /Percent	Эмчлэгдсэн хүний тоо /Number of inpatient	Хувь /Percent
5-9 ортой / 5-9 beds	7	7	881.5	1.4
10-14 ортой / 10-14 beds	19	19	6399.5	10.5
15-19 ортой / 15-19 beds	27	27	9936	16.4
20-25 ортой / 20-25 beds	27	27	16899.5	27.8
29-30 ортой / 29-30 beds	10	10	5885	9.7
39-50 ортой / 39-50 beds	5	5	8735	14.4
60 ба түүнээс дээш ортой /Over 60 beds	5	5	11926	19.6
Нийт дүн /Total	100	100	60662.5	100.0

Ор бүхий хувийн эмнэлэгт эмчлэгдсэн хүний тоо, тасгаар, 2018 он
Number of inpatient for private hospitals, by type or health care services, 2018





БҮЛЭГ IV. НИЙСЛЭЛИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫН БҮТЭЦ, ХҮНИЙ НӨӨЦ

Монгол Улсын Эрүүл мэндийн салбарт 2018 онд нийт 52274 ажиллагсад эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлж байна. Энэ нь өмнөх онтой харьцуулахад 3.5 хувь буюу 1755 хүнээр нэмэгдсэн байна. Нийт ажиллагсадаас 93.2 хувь нь эрүүл мэндийн салбарын, 6.8 хувь нь бусад салбарын эрүүл мэндийн ажиллагсад эзэлж байна. Эрүүл мэндийн нийт ажиллагсдын 11.2 мянга нь их эмч, 2.1 мянга нь эм зүйч, 12.3 мянга нь сувилагч, 7.8 мянга нь эмнэлгийн тусгай мэргэжлийн бусад ажилтан байна.

CHAPTER IV. STRUCTURE OF THE HEALTH ORGANIZATIONS OF THE CITY, HUMAN RESOURCES

As of 2018, totally 52,274 health care professionals are providing health care and service in the health sector. This figure is 1755 people or 3.5% higher compared to the previous year. Out of total workforce, 93.2% occupied in the health sector, whereas 6.8% are occupied in other sector of health care. Of the total health care employees, 11.2 thousand are physicians, 2.1 thousand are pharmacists, 12.3 thousand are nurses and 7.8 thousand are medical technicians and other medical staffs.

Эрүүл мэндийн салбарын ажиллагсад, 2018 он
Health professionals, 2018

Үзүүлэлт /Indicator		Улсын хэмжээнд /Country	Улаанбаатарт /Ulaanbaatar
Нийт ажиллагсад /Total staff	Бодит тоо /Absolute number	52274	28544
	10000 хүн амд /Per 10000 population	165.5	199.5
Үүнээс/ Of these			
Их эмч /Physician	Бодит тоо /Absolute number	11169	6895
	10000 хүн амд /Per 10000 population	35.4	48.2
Сувилагч /Nurse	Бодит тоо /Absolute number	12344	6573
	10000 хүн амд /Per 10000 population	39.1	45.9
Эх баригч /Medwife	Бодит тоо /Absolute number	1014	306
	10000 хүн амд /Per 10000 population	3.2	2.1
Лаборант /Laboratory technicians	Бодит тоо /Absolute number	1162	488
	10000 хүн амд /Per 10000 population	3.6	3.4
Техникч /Technician	Бодит тоо /Absolute number	625	475
	10000 хүн амд /Per 10000 population	1.9	3.3
Эм найруулагч /midlevel pharmacist	Бодит тоо /Absolute number	1934	764
	10000 хүн амд /Per 10000 population	6.1	5.3
Бага эмч /Nurse-practitioners	Бодит тоо /Absolute number	2410	237
	10000 хүн амд /Per 10000 population	7.6	1.6
Бусад-Other	Бодит тоо /Absolute number	681	438
	10000 хүн амд /Per 10000 population	2.1	3.0



Нийслэлийн хэмжээнд нийт 2617 эрүүл мэндийн байгууллагад 28544 ажиллагчид ажиллаж байгаагаас удирдах ажилтан 936, нийгмийн эрүүл мэндийн мэргэжилтэн 559, мэдээлэл технологийн мэргэжилтэн 168, их эмч 6895, эм зүйч 1503, бусад дээд мэргэжилтэн 3078, эмнэлгийн тусгай мэргэжлийн мэргэжилтэн 9281 байгаагаас сувилагч 6573, эм найруулагч 764, бага эмч 237, техникч 475, лаборант 488, эх баригч 306 тус тус ажиллаж байна.

Нийт ажиллагсдын:

- өрх, тосгоны эрүүл мэндийн төвд 6.6,
- дүүргийн эрүүл мэндийн төвд 10.5,
- нэгдсэн эмнэлэгт 3.2,
- төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвд 0.9,
- хувийн эмнэлэг, эмийн сангуудад 40.0,
- амаржих газар болон бусад эрүүл мэндийн байгууллагад 8.9,
- бусад салбарын эрүүл мэндийн байгууллагад 9.9 хувь нь ажиллаж эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлсэн байна.

Насны бүтцээр авч үзэхэд 0.2 хувь нь 20-иос доош, 27.1 хувь нь 20-29 нас, 28.5 хувь нь 30-39 насны, 23.6 хувь нь 40-49 насны, 11.0 хувь нь 50-54 насны, 6.3 хувь нь 55-60 насны, 3.1 хувь нь 60-аас дээш насныхан эзэлж байна. Нийт ажиллагсдын 81.9 хувь нь эмэгтэй, 18.1 хувь нь эрэгтэй байна.

Улаанбаатар хотод нэг эмчид ногдох хүний тоо 208, нэг сувилагчид ногдох хүний тоо 218 байна.

Нийт их эмч нарын 7.4 хувийг уламжлалт анагаахын, 14.5 хувийг нүүр амны их эмч, 78.1 хувийг бусад мэргэшлийн их эмч тус тус эзэлж байгаа бөгөөд хүний их эмчийн 20.0 хувь нь ерөнхий мэргэжлийн, 80.0 хувь нь үндсэн ба төрөлжсөн мэргэжлийн эмч нар байна. Үндсэн ба төрөлжсөн мэргэжлийн эмч нарын 16.3 хувь нь дотор, 8.1 хувь нь хүүхэд, 9.2 хувь нь дүрс оношилгоо, 6.3 хувь нь лаборатори, 8.2 хувь нь мэс засал, 4.8 хувь нь мэдрэл, 6.9 хувь нь мэдээгүйжүүлэлт, эрчимт эмчилгээний эмч нар эзэлж байна.

In the capital city, there are 28,544 employers work at 2617 health care facilities by administrators 936, public health professionals 559, information technology specialists 168, doctors 6895, pharmacists 1503, other specialists 3078, special medical specialists 9281, nurses 6573, pharmacists 764, nurse-practitioners 237, technicians 475, medical labrotorists 488, midwives 306.

Of the total workforce:

- 6.6% are working in the family and village health centers,
- 10.5 are working in the district health centers,
- 3.2% are in general hospitals
- 20.9% are in central and specialized hospitals
- 40.0% are in the private hospital and pharmacies
- 8.9% are in maternity hospitals and other health organizations
- 9.9% are working in other health sector organizations to provide health care.

0.2% of total staff were below-20 years old, 27.1% were aged between 20-29, 28.5% were aged between 30-39, 23.6% were aged between 40-49, 11.0% were aged between 50-54, 6.3% were aged between 55-60, and 3.1% were physicians aged above 60. Out of all staffs, 81.9% are female and 18.1% are males.

In Ulaanbaatar city, an average number of patients per one physician is 208 whereas average number of patients per one nurse is 218.

7.4% of total physicians are specialized in traditional medicine, 14.5% specialized in dentists or maxilla facial and oral specialist, 78.1% are physicians with different specialization. Out of all physicians, 20.0% are general practitioners, and 80.0% are general and specialized subspecialty. Out all off physicians with general and specialized subspecialty, 16.3% were specialized in internal medicine, 8.1% were specialized in pediatrics, 9.2% were specialized in radiology, 6.3% were specialized in laboratory, 8.2% were specialized in surgery, 4.8% were in neurology, 6.9% were specialized in anesthesiology and intensive care.




Эрүүл мэндийн салбарт ажиллаж буй эмч, мэргэжилтнүүдийн 7005 буюу 13.4 хувь нь мэргэжлийн зэрэгтэй, 3184 буюу 6.1 хувь нь боловсролын зэрэгтэй байна.

Эрүүл мэндийн салбарын нийт их эмч нарын 12.9 хувь нь ахлах, 9.3 хувь нь тэргүүлэх зэрэгтэй, 12.3 хувь нь магистр, 0.7 хувь нь анагаах ухааны доктор, 1.3 хувийг доктор эзэлж байна. Эмнэлгийн тусгай мэргэжилтнүүдийн 15.3 хувь нь ахлах, 4.4 хувь нь тэргүүлэх зэрэгтэй, 0.7 хувь нь магистрын зэрэгтэй эмнэлгийн дунд мэргэжилтнүүд ажиллаж байна.

Out of all health care professionals working in the health sector of the capital city, 7005 or 13.4% have professional degree, 3184 or 6.1% have educational degree.

12.9% of the total health care workforce working in the health sector are physicians with higher rank, 9.3% are physicians with highest rank, 12.3% have master's degree, 0.7% have doctoral degree (Ph.D.) and 1.3% have science doctorate degree (D.Sc.). For mid-level professionals, 15.3% are professionals with higher rank, 4.4% are professionals with highest rank, 0.7% have master's degree.

Нийт ажиллагсад, их эмч, тусгай мэргэжилтэн, 10000 хүн амд, 2009-2018 он
Total staff, physician, nurse, per 10000 populations, 2009-2018





**Нийслэлийн эрүүл мэндийн газрын харьяа эрүүл мэндийн байгууллагын эмч
ажиллагсад, бодит тоогоор, 2018 он**
Number of total staff of state hospitals under Ulaanbaatar city Health Department, 2018

Эрүүл мэндийн байгууллага /Type of Health facility		Нийт ажиллагчид /Total staff	Их эмч /Doctors	Сувилагч /Nurses	Эмч сувилагчийн харьцаа /Ratio doctors/nurses
Өрхийн эрүүл мэндийн төв /Family health center		1762	652	613	1:0.9
Тосгоны эрүүл мэндийн төв /Village health center		124	30	28	1:0.9
Эрүүл мэндийн төв /District health centers	Баянгол /Bayangol	396	117	116	1:0.9
	Баянзүрх /Bayanzurkh	256	97	48	1:0.5
	Сонгинохайрхан /Songinokhairhan	389	110	107	1:0.9
	Сүхбаатар /Sukhbaatar	199	61	40	1:0.6
	Хан-Уул /Khan-Uul	224	70	62	1:0.8
	Чингэлтэй /Chingeltei	357	99	113	1:1.1
	Налайх /Nalaikh	347	78	105	1:1.3
	Багануур /Baganuur	309	76	112	1:1.5
Нэгдсэн эмнэлэг /District general hospitals	Баянзүрх /Bayanzurkh	288	66	111	1:1.7
	Сонгинохайрхан /Songinokhairhan	124	20	46	1:2.3
	Сүхбаатар /Sukhbaatar	236	41	75	1:1.8
	Хан-Уул /Khan-Uul	149	34	46	1:1.4
Амаржих газар /Maternity hospitals	Өргөө /Urguu	487	105	139	1:1.3
	Хүрээ /Khuree	182	34	27	1:0.8
	Амгалан /Amgalan	258	59	37	1:0.6
Бусад эмнэлэг /Other hospitals		964	271	135	1:0.5



БҮЛЭГ V. ХАЛДВАРТ ӨВЧИН

Улсын хэмжээнд 27 төрлийн цочмог халдварт өвчний 42074 тохиолдол бүртгэгдэж, 10000 хүн амд 132.4 байна. Өмнөх онтой харьцуулахад 2226 тохиолдлоор буюу 10000 хүн амд 12.0-оор буурсан байна.


Улаанбаатар хотод халдварт өвчний нийт 22931 тохиолдол бүртгэгдэж, 10000 хүн амд 163.9 байна. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 3877 тохиолдол буюу 10000 хүн амд ногдох өвчлөл 32.8 тохиолдлоор буурсан байна.

CHAPTER V.COMMUNICABLE DISEASES


In 2018, a total of 42,074 cases with 27 different acute infectious diseases were registered nationwide which is 132.4 per 10,000 population. Compared to previous year, the incidence rate was decreased by 12.0 cases per 10,000 (total of 2,226 cases).

In UB city, total of 22,931 communicable disease cases were reported. Incidence rate is estimated to be 163.9 per 10,000 population. The rate was decreased by 32.8 cases per 10,000 population (3,877 cases) compared the previous year.

Бүртгэгдсэн халдварт өвчин, 10000 хүн амд, 2009-2018 он
Registered communicable diseases, per 10000 population, 2009-2018



Халдварт өвчний бүтэц, хувиар, 2018 он Structure of communicable diseases, 2018



Нийт халдварт өвчний 34.8 хувийг амьсгалын замын халдварт өвчин, 30.1 хувийг бэлгийн замын халдварт өвчин, 34.1 хувийг гэдэсний халдварт өвчин, 0.8 хувийг бусад халдварт өвчин, 0.2 хувийг зоонозын халдварт өвчин тус тус эзэлж байна.

In 2018, 34.8% of all communicable diseases registered in the UB city were infectious of respiratory diseases, 30.1% were sexually transmitted infections, 34.1% intestinal infections, 0.2% were zoonotic bacterial diseases and 0.8% were other infections.

5.1. АМЬСГАЛЫН ЗАМЫН ЦОЧМОГ ХАЛДВАРТ ӨВЧИН

Улаанбаатар хотод амьсгалын замын халдварт өвчний 7990 тохиолдол бүртгэгдсэн нь өмнөх оноос 2250 тохиолдлоор буурсан байна. 10000 хүн амд 57.1 тохиолдол бүртгэгдсэн байна.

Амьсгалын замын халдварт өвчний бүтцээс харахад нийт өвчний 58.6 хувийг салхинцэцэг, 25.9 хувийг сүрьеэ, 10.6 хувийг улаан эсэргэнэ, 2.8 хувийг гахай хавдар, 2.1 хувийг бусад өвчин эзэлж байна.


5.1. RESPIRATORY INFECTIONS

In 2018, 7990 cases of infectious disease of respiratory system were registered which is an decrease by 2250 cases compared to the previous year. The rate respiratory infections were registered 57.1 per 10,000 population.

Majority of the respiratory infectious were varicella (58.6), tuberculosis (25.9), scarlet fever (10.6), mumps (2.8) and others (2.1).



Амьсгалын замын халдварт өвчний бүтэц, хувиар, 2017-2018 он Structure of respiratory infections, by percentage, 2017-2018



Гахай хавдар

Улсын хэмжээнд гахай хавдар өвчний 319 тохиолдол бүртгэгдсэний 69.0 (n=223) хувь нь Улаанбаатар хотод бүртгэгдсэн байна. 10000 хүн амд 1.6 байгаа нь өмнөх онтой харьцуулахад 103 тохиолдол буюу 10000 хүн амд 0.7-оор нэмэгдсэн байна.

Гахай хавдар өвчний нийт тохиолдлын дийлэнх буюу 84.0 хувь нь 0-19 насныхан, 12.0 хувь нь 20-39 насны хүмүүст бүртгэгдсэн байна.

Ялангуяа 5-9 насны хүүхдүүд нийт тохиолдлын 41.0 хувийг эзэлж байгаа нь цэцэрлэг болон сургуулийн насныханд илүү тохиолдсон байна.


Mumps

In 2018, 69.0 % (n=223) of the total mumps 319 cases were reported in UB city. Compared to previous year, the incidence rate was increased by 1.6 cases per 10,000 population (103 cases) reaching 0.7 per 10,000 population.

The majority (84.0%) of total mumps cases reported among 0-19 year olds, and 12.0% among 20-39 year olds.

Children aged 5-9 accounted for 41.0% of the total cases mostly affecting children kindergarden and schools children.

Гахай хавдар өвчний хөдлөл зүй, бодит тоо, сараар, 2017-2018 он Number of mumps by season, by month, 2017-2018






Салхинцэцэг

Улсын хэмжээнд салхинцэцэг өвчний 8130 тохиолдол бүртгэгдсэний 57.6 хувь нь Улаанбаатар хотод бүртгэгдсэн байна. Улаанбаатар хотод өвчлөлийн 4680 тохиолдол бүртгэгдсэн ба өмнөх онтой харьцуулахад 10000 хүн амд 9.7-оор буурсан байна.

Varicella

8130 cases of varicella were registered across the country and 57.6% (n=4680) of them occurred in Ulaanbaatar. The incidence rate per 10000 population decreased by 9.7 cases compared to previous year.


Салхинцэцэг өвчний хөдлөл зүй сараар, бодит тоо, 2018 он
Number of varicella, by months, 2018



Улиралчлал: Салхинцэцэг өвчний эпидемиологийн хөдлөл зүйг авч үзэхэд 1-6 сард ихэсч, 7 сард бага зэрэг буурч, 8 сараас огцом буурч дахин 10 сараас ихэссэн үзүүлэлттэй байна.

Seasonal variations: Incidence of varicella increased during January to June and slightly decreased in July. It sharply decreased in August and increased again in October.

Салхинцэцэг өвчин, насны ангиллаар, хувиар, 2018 он
Varicella by age groups, by percentage, 2018



Насны бүтцээр авч үзэхэд 85.8 хувь нь 0-15 насны хүүхэд байгаа бол үүнээс 29.2 хувь нь гэртээ, 18.7 хувь нь сургуулийн, 52.1 хувь нь бага насны хүүхдүүд байна

By age specific morbidity, 85.8% was registered in 0-15 year olds, 29.2% of them was home, 18.7% school children, and 52.1% kindergarden children.



Менингококкт халдвар

Улсын хэмжээнд менингококкт халдварын 12 тохиолдол бүртгэгдсэн байна. Нийслэлд менингококкт халдварын 7 тохиолдол бүртгэгдсэн байна. Тогтмол хаягаар авч үзэхэд Баянзүрх-1, Сонгинохайрхан-1, Чингэлтэй-3, Сүхбаатар-1, Налайх-1 тохиолдол тус тус бүртгэгдсэн байна. Эдгээр тохиолдол 0-5 насны хүүхдүүд бүртгэгдсэн байна.

Сүрьеэ

Монгол улс Номхон далайн баруун бүсийн орнуудаас өвчлөл өндөртэй 7 орны тоонд ордог бөгөөд өвчлөлийн талаас илүү хувь нь улсын нийслэлд бүртгэгддэг.

Улсын хэмжээнд сүрьеэ өвчний нийт 3498 шинэ тохиолдол бүртгэгдсэн нь нийт халдварт өвчний дотор 8.3 хувийг эзэлж байна. 10000 хүн амд ногдох өвчлөл 11.0 байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 1.4 промилль буюу 281 тохиолдлоор буурсан байна.

Шинэ тохиолдлын дотор уушгины сүрьеэ 2113 (60.4%), уушгины бус эрхтний сүрьеэ 1385 (39.6%) бүртгэгдсэн нь өнгөрсөн онтой харьцуулбал уушгины сүрьеэ 6 тохиолдол буюу 0.3 хувиар нэмэгдэж, уушгины бус эрхтний сүрьеэ 287 тохиолдлоор буюу 17.2 хувиар тус буурсан байна.

Шинээр бүртгэгдсэн сүрьеэгийн нийт өвчлөлийн 2025 (57.9%) нь УБ хотод, 1429 (40.9%) нь аймаг орон нутагт, 44 (1.2%) нь хорих байгууллагад бүртгэгдсэн байна.

Meningococcal infection

12 cases of meningococcal infection were registered in nationwide. In Ulaanbaatar, 7 cases meningococcal infection were registered. 1 of the cases were reported in Bayanzurkh district, 3 in Chingeltei, 1 in Songinokhairkhan, 1 in Sukhbaatar and 1 in Nalaikh. All cases were registered children aged 0-5.

Tuberculosis

Mongolia is among the seven most-affected countries in the Western Pacific Region. More than half of all illnesses are occur in the capital city.


In 2018, 3498 new cases of tuberculosis were registered nationwide which accounted for 8.3% of the total cases of communicate disease. Incidence rate per 10,000 population is 11.0 which decreased by 1.4 cases per 10000 population (281) compared to the previous year.

Of the new cases 60.4% (2113) was pulmonary and 39.6% (1,385) was extra pulmonary tuberculosis. Compared to previuos year, pulmonary tuberculosis cases increased by 0.3 percent (6 cases) and extra pulmonary tuberculosis cases decreased by 17.2 percent (243 cases).

57.9% of total new cases (2025) were reported in UB, 40.9% (1429) in the aimags and 1.2% (44) in detention centers.



Сүрьеэгийн өвчин, 10000 хүн амд, сүүлийн 10 жилээр
Tuberculosis, per 10000 population, by last 10 years



Улаанбаатар хотод сүрьеэгийн өвчлөлийн 2069 тохиолдол бүртгэгдсэн нь нийт өвчлөлийн 59.1 хувийг эзэлж байна. 10000 хүн амд ногдох сүрьеэгийн өвчлөл 14.8 байгаа нь өмнөх оноос 1.8-аар буурсан байна.

In Ulaanbaatar, 2,069 cases of tuberculosis were reported, which accounted for 59.1 percent of all cases. In 2018, incidence of tuberculosis per 10,000 population was 14.8, which is decrease by 1.8 cases per 10,000 compared to the previous year.

Сүрьеэгийн өвчин, 10000 хүн амд, дүүргээр, 2017-2018 он
Registered tuberculosis, by district, 2017-2018


Дүүрэг /District	2017		2018		"Өсөлт /бууралт/" Increase/ decrease	
	Бодит тоо /Abs number	10000 хүн амд /10000 per pop	Бодит тоо /Abs number	10000 хүн амд /10000 per pop	Бодит тоо /Abs number	10000 хүн амд /10000 per pop
Баянгол /Bayangol	305	14.5	282	12.9	-23	-1.6
Баянзүрх /Bayanzurkh	547	16.9	516	15.5	-31	-1.3
Сонгинохайрхан /Songinokhairkhan	555	17.8	478	15.0	-77	-2.8
Сүхбаатар /Sukhbaatar	169	12.3	163	11.9	-6	-0.5
Хан-Уул /Khan-Uul	253	16.3	223	13.5	-30	-2.8
Чингэлтэй /Chingeltei	257	16.4	263	16.6	6	0.2
Налайх/ Nalaikh	48	13.3	53	14.5	5	1.2
Багануур /Baganuur	22	7.7	24	8.3	2	0.6
Багахангай /Bagakhangai	2	4.8	0	0.0	-2	-4.8
Бусад эмнэлэг /Other hospital	103	-	67	-	-36	-
Улаанбаатар /Ulaanbaatar	2261	16.6	2069	14.8	-192	-1.8



2018 онд 10000 хүн амд ногдох өвчлөл Баянзүрх, Сонгинохайрхан дүүргүүдэд нийслэлийн дундаж үзүүлэлтээс өндөр байна. Улсын хэмжээнд бүртгэгдсэн сүрьеэгийн нийт тохиолдлын 59.1 хувь Улаанбаатар хотод, 28.4 хувийг Сонгинохайрхан, Баянзүрх дүүргийн харьяаллын хүн амын өвчлөл эзэлж байна.

Incidence rate of tuberculosis is higher than capital city average in Bayanzurkh, Songinokhairkhan Districts. 59.1% of total UB cases and 28.4% of total cases of Mongolia were from only 2 districts in UB, namely Songinokhairkhan and Bayanzurkh.

Сүрьеэгийн шинэ өвчлөл, насны ангиллаар, хувиар, 2018 он
Incidence of tuberculosis, by age, by percentage, 2018



Шинээр илэрсэн сүрьеэтэй өвчтөний 65.4 хувийг 15-44 насныхан эзэлж байгаа нь залуу хөдөлмөрийн насны хүмүүс илүүтэй өвчилж байгааг харуулж байна. Хүйсийн хувьд 56.0 хувийг эрэгтэйчүүд 44.0 хувийг эмэгтэйчүүд эзэлж байна.

Looking by age group, accounts for 65.4 percent among young adults of labor-active age 15-44. 56.0% of total cases were males and the rest were females (44.0%).

Улсын хэмжээнд 0-15 хүртэлх насны хүүхдийн сүрьеэгийн 334 тохиолдол бүртгэгдсэн нь нийт сүрьеэгийн шинэ өвчлөлийн 9.5 хувийг эзэлж байна.

In 2018, 334 a total of cases tuberculosis were registered among children aged 0-15 which accounted for 9.5% of total tuberculosis new cases in the national level.

Улаанбаатар хотод 224 хүүхэд сүрьеэгээр өвчилсөн нь нийт хүүхдийн сүрьеэгийн өвчлөл дотор 67.1 хувийг эзэлж байгаа нь өмнөх оноос 6.5-өөр буурсан байна.

In Ulaanbaatar, 224 (67.1%) children were newly diagnosed with tuberculosis. Percentage of childhood tuberculosis decrease by 6.5 compared to the previous year.

Шинэ халдвартай сүрьеэтэй өвчтөний эмчилгээний амжилт 85.9 хувь, эдгэрэлт 72.0 хувь байгаа нь 2017 оноос эмчилгээний амжилт 1.1 хувь нэмэгдэж, эдгэрэлт 2.9 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Жил тутам сүрьеэ өвчний улмаас хөдөлмөрийн чадвар алдалтын группт орох хүний тоо нэмэгдэж байгаа ба тэр дундаа 70 хувиас дээш группт орох нь улам бүр өссөөр байна. 2018 онд нийт 2664 өвчтөн группт орсон ба үүний 2548 (96.8%) нь 70 хувиас их, 86 (3.2%) нь 50-69 хувийн хөдөлмөрийн чадвар алдалттай болсон байна.

Treatment success rate of the newly diagnosed active tuberculosis cases was 85.9% with cure rate of 72.0%. Compared to the previous year, treatment success was increased by 1.1 although cure rate was decreased 2.9%.

Disability due to tuberculosis, patients with 70% loss of work ability in particular, has been steadily increasing each year. In 2018, out of 2,664 patients newly covered by disability benefit package were due to tuberculosis. 2,548 (96.8%) of them had 70% or more and 86 (3.2%) had 50-69% loss of work ability.




Олон эмэнд тэсвэртэй сүрьеэ:

Улсын хэмжээнд 2018 онд олон эмэнд тэсвэртэй сүрьеэгийн 224 тохиолдол шинээр оношлогдсон нь 100 000 хүн амд 7.2 болж өмнөх оноос 0.8 промилиор буурсан үзүүлэлттэй байна. Олон эмэнд тэсвэртэй сүрьеэ өвчний 67.9 хувь нь Улаанбаатар хотод, 31.6 хувь нь орон нутагт тус тус оношлогдсон байна.

Multidrug Resistent Tuberculosis (MDR-TB):

In 2018, 224 new cases of MDR tuberculosis were diagnosed with incident rate of 7.2 per 100,000 population. The rate decreased by 0.8 cases per 100000. 67.9% of total MDR tuberculosis were reported in UB and the rest (31.6%) in rural areas.

Олон эмэнд тэсвэртэй сүрьеэгийн тохиолдлын түвшин, 100 000 хүн амд
Number of multi drug resistant tuberculosis, per 100 000 population





Халдвартай хэлбэрийн сүрьеэтэй өвчтөнг бүрэн төгс эмчилснээр сүрьеэгийн халдварлалтын гинжин хэлхээг таслан зогсоох бөгөөд ДЭМБ халдвартай сүрьеэтэй өвчтөний 85 хувийг эдгээх зорилт тавьдаг бол Улаанбаатар хотод эдгэрэлт 2017 онд 68.6 хувь байсан нь 2018 онд 75.8 хувь болж 7.2-оор нэмэгдсэн байна. Эмчилгээний амжилт 82.8 хувь байгаа нь өнгөрсөн онтой харьцуулахад 2.8 хувиар өссөн байна.


Complete treatment of active form of tuberculosis is the way to stop the transmission chain and achieve WHO target for 85% cure rate of infectious tuberculosis.

The cure rate was 68.6% back in 2017, however, it has increased up to 75.8% (by 7.2 points) over the past years. On the other hand, treatment success rate reached 82.8% increased by 2.8 point compared to last year.

Сүрьеэ өвчний тархалт, нас баралтын түвшин 100 000 хүн амд, сүүлийн 10 жилээр
Prevalence and death rate of tuberculosis, per 100 000 population, by last 10 years

Үзүүлэлт/ Indicator	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018
Сүрьеэгийн өвчлөлийн түвшин /Prevalence of tuberculosis										
Улсын дундаж /Country average	157	154	143	139	142	141	141	131	122	113
УБ хот /UB city average	199	189	174	170	179	187	155	174	156	145
Аймгийн дундаж /Aimag average	131	136	126	119	110	101	131	94	91	84
ДОТС-ын хүрээнд эмчилсэн сүрьеэгийн тохиолдлын хувь /Proportion of tuberculosis cases detected and cured under DOTS										
Улсын дундаж /Country average	100 /82.4	100 /84.5	100 /83.0	100 /82.7	100 /80.1	100 /80.7	100 /79.5	100 /81.2	100 /84.8	100 /85.9
УБ хот /UB city average	100 /80.7	100 /81.7	100 /79.8	100 /78.0	100 /76.0	100 /77.1	100 /74.3	100 /74.9	100 /80.0	100 /82.8
Аймгийн дундаж /Aimag average	100 /87.8	100 /87.5	100 /87.3	100 /89.2	100 /84.7	100 /85.2	100 /88.3	100 /87.6	100 /91.0	100 /90.1

Сүрьеэ өвчний нас баралтын түвшин, 10000 хүн амд, 2012-2018 он
Death rate of tuberculosis, per 10000 population, 2012-2018





Улаанбурхан

Улсын хэмжээнд улаанбурхан өвчний 1 тохиолдол бүртгэгдсэн нь 10000 хүн амд 0.01 байна. Улаанбаатар хотод бүртгэгдээгүй байна.

5.2. ГЭДЭСНИЙ ХАЛДВАР

2018 онд Улаанбаатар хотод гэдэсний халдварт өвчний 7816 тохиолдол бүртгэгдсэн нь өмнөх оноос 120 тохиолдлоор буурсан байна. Гэдэсний халдварт өвчний 66.7 хувь нь цусан суулга, 4.2 хувь нь хоолны хордлого, 3.8 хувь нь сальмонеллэз, 2.3 хувь нь А хепатит, 21.5 хувь нь гар, хөл амны өвчин тус тус эзэлж байна.


Measles

1 cases of measles were registered across the country and it is 0.01 per 10000 population. Not registered in Ulaanbaatar.

5.2. INTESTINAL INFECTION

In 2018, a total of 7816 cases of intestinal infection were registered. Compared to the previous year it declined by 120 cases. Shigellosis, food poisoning, salmonella infections, Hepatitis A and hand-foot-mouth disease were accounted for 66.7%, 4.2%, 3.8%, 2.3% and 21.5% respectively.

Гэдэсний халдварт өвчний бүтэц, хувиар, 2018 он
Structure of intestinal infection, by percentage, 2018



Цусан суулга

Гэдэсний халдварт өвчний 66.7 хувийг цусан суулга өвчин эзэлж байна. Цусан суулга өвчний 5214 тохиолдол бүртгэгдэж 10000 хүн амд 37.3 байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 12.4-өөр өссөн байна.

Dysentery (shigelliosis)

Shigellosis were accounted for 66.7% of intestinal infection. 5214 cases of Shigellosis or 37.3 cases per 10,000 populations were registered showing escalation of 12.4% than the previous year.



Дүүргүүдээр харьцуулахад: Баянзүрх, Сонгинохайрхан дүүргүүдэд хотын дунджаас өндөр байна. Нийслэлийн нийт өвчлөлийн 28.0 хувь нь Баянзүрх, 24.4 хувь нь Сонгинохайрхан, 9.8 хувь нь Чингэлтэй, 11.5 хувь нь Баянгол, 8.6 хувь нь Сүхбаатар, 10.6 хувь нь Хан-Уул, 0.4 хувь нь Налайх, 0.9 хувь нь Багануур, 0.2 хувь нь Багахангай дүүрэгт тус тус бүртгэгдсэн байна.

Цусан суулга өвчний 87.5 хувь нь эмнэл зүйгээр, 12.5 хувь нь эмнэл зүйн лабораторийн давхар шинжилгээгээр тус тус онош тогтоогдсон байна.

Нийслэлийн хэмжээнд бүртгэгдсэн цусан суулга өвчний халдварыг эх уурхайгаар нь авч үзэхэд 12.9 хувь нь өвчтөнөөс, 87.1 хувь нь тогтоогдоогүй байна.

Сальмонеллёз

Улсын хэмжээнд бүртгэгдсэн (n=329) сальмонеллёзын өвчлөлийн 90.0 хувь нь Улаанбаатар хотод бүртгэгдсэн байна. Улаанбаатар хотод сальмонеллёзын өвчлөл 10000 хүн амд 2.1 байна.

Гар, хөл, амны өвчин

Улсын хэмжээнд бүртгэгдсэн (n=2876) гар, хөл, амны өвчлөлийн 58.4 хувь нь Улаанбаатар хотод бүртгэгдсэн байна. Улсын хэмжээнд бүртгэгдсэн гар, хөл, амны өвчний 96.5 хувийг 0-9 насны хүүхдийн өвчлөл эзэлж байна. Улаанбаатар хотод гар, хөл, амны өвчлөл 10000 хүн амд 12.0 байгаа нь өмнөх онтой харьцуулахад 19.3-аар буурсан байна. Багануур дүүрэгт Улаанбаатар хотын дунджаас өндөр байна.

Нийслэлийн нийт өвчлөлийн 32.0 хувь нь Баянзүрх, 15.4 хувь нь Сонгинохайрхан, 15.5 хувь нь Баянгол, 8.6 хувь нь Чингэлтэй, 11.3 хувь нь Хан-Уул, 10.0 хувь нь Сүхбаатар, 1.2 хувь нь Налайх, 3.2 хувь нь Багануур дүүрэгт тус тус бүртгэгдсэн байна. Нийслэлийн хэмжээнд бүртгэгдсэн гар, хөл, амны өвчний халдварын эх уурхай нь 8.9 хувь нь өвчтөнөөс, 91.1 хувь нь тогтоогдоогүй байна.

This rate differed by districts: Bayanzurkh, Songinokhairkhan districts had higher than the capital average. 28.0% of total cases occurred in Bayanzurkh, 24.4% in Songinokhairkhan, 9.8% in Chingeltei, 11.5% in Bayangol, 8.6% in Sukhbaatar, 10.6% in Khan-Uul, 0.4% in Nalaikh, 0.9% in Baganuur and 0.2% in Bagakhangai.

Majority of the cases (87.5) was diagnosed based on the clinical manifestations and only 12.5% were laboratory confirmed.

12.9% of cases registered in UB were considered to be transmitted via domestic contact with patients. However, in 87.1 of the cases, the source of infection remains unidentified.

Salmonella infections

In 2018, 90.0% of total 329 cases of salmonella infection reported were in Ulaanbaatar. Incidence rate of salmonella infection was 2.1 per 10000 population in Ulaanbaatar.

Hand, foot and mouth disease (HFMD)

58.4% of the total 2876 cases of HFMD were reported in Ulaanbaatar City. Incidence rate in UB city is 12.0 per 10,000 population. Children at age of 0-9 accounted for 96.5% of the total reported cases. Compared to the rate of the previous year, incident rate of HFMD declined by 19.3 cases per 10,000. Baganuur district had the highest rate above the city average.

32.0% of the total cases in UB were reported in Bayanzurkh district, 15.4% in Songinokhairkhan, 8.6% in Chingeltei, 15.5% in Bayangol, 10.0% in Sukhbaatar, 11.3% in Khan-Uul, 1.2% in Nalaikh, 3.2% in Baganuur District. The source of infection confirmed to be infected patients for only 8.9% of the cases, for the rest (91.1% of the cases) it remains unidentified.




Вирус гепатит

Улсын хэмжээнд вирус гепатит өвчний 475 тохиолдол бүртгэгдэж 10000 хүн амд 1.5 байна. Улаанбаатар хотод вирус гепатитийн 299 тохиолдол бүртгэгдсэн нь 10000 хүн амд 2.1 байна. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 28 тохиолдлоор буюу 10000 хүн амд 0.3-аар буурсан байна. Нийт тохиолдлын 2.3 хувийг вирус гепатит А, 51.2 хувийг вирус гепатит В, 21.7 хувийг вирус гепатит С, 24.7 хувийг бусад вирус гепатит тус тус эзэлж байна.

Viral Hepatitis

A total of 475 cases or 1.5 per 10,000 population of viral hepatitis were at the national level. 299 cases (2.1 per 10000 population) were registered in the Ulaanbaatar city. The incidence decreased by 28 cases compared to the previous year. Out of all viral infections, 2.3% was viral hepatitis A, 51.2% was viral hepatitis B, 21.7% was viral hepatitis C, 24.7% registered was other viral hepatitis.

